


Орчин·21

2013 01(14)

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо



2013 он усны түншлэлийн жил

2013.03.22
ДЭЛХИЙН УСНЫ
ӨДӨРТ ЗОРИУЛАВ

ЦАГ ҮЕ ҮЙЛ ЯВДАЛ

МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГОД
ТУСГАГДСАН УС ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН
ТАЛААРХИ ЗОРИЛТ
ХЭРЭГЖИЖ БАЙНА



ТА ӨВЧЛӨӨГҮЙ
ХАРИН ЦАНГАСАН
БАЙНА

МЭДЭЭЛЭЛ

АЙЛ ӨРХ, АЛБАН
БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЦЭЭНД
ЗОРИУЛАГДСАН БАГА ХҮЧИН
ЧАДЛЫН ЦЭВЭРЛЭХ
БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ
ХИЙГДЛЭЭ



ЖИГС–Ундарга ХХК

БАТАЛГААТАЙ БАТАЛГААТАЙ БАТАЛГААТАЙ

*Хэмжих хэрэгслэлийн худалдаа,
засвар үйлчилгээ ,суурилуулалт*



**DN БРЭНДИЙН ЭРГЭЛДДЭГ СЭНСЭН ХҮРДТЭЙ,
ХУУРАЙ ЦАГИЙН МЕХАНИЗМТАЙ, УРЬДЧИЛСАН
ТӨЛБӨРТ IC КАРТТАЙ ХҮЙТЭН УСНЫ ТООЛУУР**

БЕТАР АХУЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ХАЛУУН, ХҮЙТЭН УСНЫ ТООЛУУР

DN АХУЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ХАЛУУН, ХҮЙТЭН УСНЫ ТООЛУУР

ОЛОН УРСГАЛТ, ХУУРАЙ ЦАГИЙН МЕХАНИЗМТАЙ ХАЛУУН, ХҮЙТЭН УСНЫ ТООЛУУР

ХОС ТООЛОГЧТОЙ, ХЭВТЭЭ ХЭЛБЭРИЙН ХУУРАЙ ЦАГИЙН МЕХАНИЗМТЭЙ, БОСОО СЭНСЭН ХҮРДЭТ
ХАВХЛАГА БҮХИЙ ХАЛУУН, ХҮЙТЭН УСНЫ ТООЛУУР

МНААҮХОЛБООНЫ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДАД ХЯМДРАЛТАЙ

WWW.JIGS.MN

УТАС: 99117086

ОРЧИН 21


МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО

2013.03.22
**ДЭЛХИЙН УСНЫ
ӨДӨРТ ЗОРИУЛАВ**



6-17 ЦАГ ҮЙЛ ЯВДАЛ

МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГОД
ТУСГАГДСАН УС ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН
БАЙГУУЛАМЖИЙН ТАЛААРХИ ЗОРИЛТ ХЭРЭГЖИЖ
БАЙНА



18-23 МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХОЛБООНООС ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БАЙГАА
СУРГАЛТ СЕМИНАР




24-33 ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ

АЙЛ ӨРХ, АЛБАН БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЦЭЭНД
ЗОРИУЛАГДСАН БАГА ХУЧИН ЧАДЛЫН ЦЭВЭРЛЭХ
БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ХИЙГДЛЭЭ




34-37 ЯРИЛЦЛАГА

МОНГОЛЧУУД УСЫГ ӨДӨР ТУТМЫН ХЭРЭГЦЭЭГЭЭ
БОЛГОХ ХЭРЭГТЭЙ




38-43 ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА

"ЧАНДМАНЬ-БАЯНХОНГОР" ХУВЬЦААТ КОМПАНИ
БОЛОН ЗОХИОН БАЙГУУЛАГДААД БАЙНА.



44-45 ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН "ДАРХАН-УС СУВАГ" ХК-
ИЙН 2012 ОНЫ "ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА"-УУД



46-50 ХУУЛИЙН ЗӨВӨЛГӨӨ

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ
ТӨЛБӨРИЙН ТУХАЙ



51-53 ЭРҮҮЛ МЭНД

ТА ӨВЧЛӨӨГҮЙ ХАРИН ЦАНГАСАН БАЙНА

ОРЧИН 21

ЭРХЛЭГЧ:

Б.Пүрэвжав

/Монгол улсын аж үйлдвэрийн
гавьяат ажилтан, Техникийн ухааны
магистр, МУ-ын зөвлөх инженер/
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

Л.Болд /БХБЯ/

Д.Басандорж /МУШУТИС/

С.Дагвадорж

/Таван Өндөр ХХК-ийн захирал/
ДИЗАЙНЕР:

Б.Хонгорзул

ISSN 0015-154X

орчин-21

2013 01 (14) Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо

UN WATER
World Water Day
2013
International Year of
Water Cooperation
2013 он усны түншлэлийн жил



2013.03.22
ДЭЛХИЙН УСНЫ
ӨДӨРТ ЗОРИУЛАВ

ЦАГ ҮЕ ҮЙЛ ЯВДАЛ
МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГОД
ТУСГАГДСАН УС ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН
БАЙГУУЛАМЖИЙН ТАЛААРХИ ЗОРИЛТ
ХЭРЭГЖИЖ БАЙНА

ТА ӨВЧЛӨӨГҮЙ
ХАРИН ЦАНГАСАН
БАЙНА

МЭДЭЭЛЭЛ
АЙЛ ӨРХ, АЛБАН
БАЙГУУЛАГЫН ХЭРЭГЦЭЭНД
ЗОРИУЛАГДСАН БАГА ХУЧИН
ЧАДЛЫН ЦЭВЭРЛЭХ
БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ
ХИЙГДЛЭЭ

WWW.ORCHIN21.MN УТАС: 70101779 MNAALUN@YANHO.COM



ЭРХЛЭТЧИЙН ЗҮРВАС



Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт ажиллаж, иргэд олон түмэн, хэрэглэгчиддээ хэрэгцээний халуун, хүйтэн ус, дулаан, цахилгаанаар хангах үйлчилгээг найдвартай, тасралтгүй гүйцэтгэж буй уншигч, захиалагч та бүхний амрыг эрж "Орчин. 21" сэтгүүлийн хамт олноос мэндчилж байна. Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооноос эрхлэн гаргаж байсан сэтгүүл маань энэ оноос эхлэн "Орчин.21" хэмээх оноосон нэртэй болж, агуулга, нийтлэлийн хүрээгээ тэлж, өнгө цээмж, хэв маягийн хувьд сайжран уншигч таны гар дээр очиж байна. "Орчин.21" сэтгүүл эх дэлхий, эх орны хүрээлэн буй орчин, байгууллага хамт олны болоод гэр бүл, хувь хүн таны орчны талаар, шинэ 21-р зуунд үйл ажиллагаагаа эрхлэн явуулах салбарынхаа бүтээн байгуулалт, хөгжил дэвшлийн түүхийг бичих үүрэг хүлээж байна.

Мөн салбар эрхэлсэн яам, агентлаг болон төр засгийн бусад байгууллага, салбарын мэргэжлийн төрийн бус байгууллагуудын ажил төрлийн үйлдвэр, хамтын ажиллагаа, нэвтэрч буй шинэ техник технологи, үйл ажиллагааны талаар дугаар бүрийнхээ мэдээлэлд тогтмол оруулж байх болно.

Энэ оны эхний дугаараа олон улсын хэмжээнд жил бүрийн 3-р сарын 22-нд уламжлал болгон тэмдэглэдэг "Дэлхийн усны өдөр"-ийг тохиолдуулан гаргаж байна.


Бидний хамтын хөдөлмөр Монгол орныхоо хөгжил дэвшил, ард түмнийхээ энх тунх, тав тухтай сэтгэл хангалуун амьдрах үйл хэрэгт жинтэй, хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Захиалагч, уншигч иргэдийнхээ өмнө манай сэтгүүл байнга нээлттэй байх болно. Иймд та бүхнийг сэтгүүлийнхээ итгэлтэн бичигч байхыг урьж байна.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

Хүндэтгэсэн:

Сэтгүүлийн эрхлэгч, Монгол улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан, Техникийн ухааны магистр, МУ-ын зөвлөх инженер



Б.Түрэвжав


WATER STATS

Дэлхийн нийт усны нөөцийн 97,5% ийг далай тэнгисийн ус, зөвхөн 2,5% ийг цэвэр ус тус тус эзэлдэг байна.




Нийт цэвэр усны 70% нь мөнх цас мөсөн бүрхэвч эзэлдэг байна

Нийт цэвэр усны зөвхөн 1% нь ундны усанд тохиромжтой байдаг ба энэхүү усыг бид гол мөрөн гүний эх үүсвэрээс олборлодог



Дэлхийн өнцөг булан бүрийн улс орон даяар усны ашиглалт аюултай түвшинд хүрч байна. Энэ нь бүс нутгийн хүн амын өсөлт, газар тариалан, аж үйлдвэрээс болж байна.

Усны аюултай түвшинд хүрч буй улс орнууд



УСНЫ ТАЛААР ЗӨВШИЛЦӨЛД ХҮРСЭН БАРИМТ БИЧИГҮҮД

- 1989-1992 Ус ашиглалтын төлөвлөгөө гаргасан
- 1994 Химийн хорт бодисоос үүсэх бохирдлоос хамгаалах UNECE зохицуулалт удирдамж гаргасан.
- 1999 Аралын тэнгисийг хамгаалах олон улсын гэрээ хийгдсэн
- 2001 Беларус-Украин ба Хятад-Казахстан улсын хоорондын гэрээ хийгдсэн
- 2003 Унгар-Румын ба Эстони-Латив улсын хоорондын гэрээ хийгдсэн
- 2006 Усан далан байгууламжийн төсөл төв азид хэрэгжиж эхэлсэн.
- 2007 Франц гурвалсан гэрээ байгуулсан.
- 2008 Усны чанарын төсөл Төв азид хийгдэж эхэлсэн
- 2012 Усны тухай захирамж улс орнуудад түгэж мөрдөгдөж эхэлсэн

3rd WORLD 1st WORLD

ХӨГЖИХ БҮЙ УЛС ОРНУУД

ХӨГЖИНГҮЙ УЛС ОРНУУД

1. Хүн өдөрт хоол хийх цэвэрлэгэнд 20-50 литр ус хэрэглэн гэж тооцож гаргасан байна
2. Дэлхийд 6 хүн тутмын нэг буюу 894 сая хүн усны эх үүсвэр, нөөцөөс хал байдаг гэсэн судалгаа бий.
3. Усны хүрэлцээгүй байдал, ариун цэвэр болон ундны усны бохирдлоос үүссэн суулгалт өвчин нь нийт суулгалт өвчний 88% -ийг эзэлж байна.
4. Өнөөдөр 2,5 тэрбум хүн, 1 тэрбум хүүхэд ундны уснаас үүсэлтэй суулгалт өвчнөөс болж эмнэлгийн анхан шатны тусламж авч чадахгүй байна.
5. 20 секунд тутамд айхон шатны тусламжийн хүрэлцээгүйгээс болж 1 хүүхэд нас бардаг бөгөөд энэ нь жилд 1,5 сая болж байна.

1. АНУ-ын Хүрээлэн буй орчны хамгаалалын төвөөс гаргасан тооцоогоор 1,25 миллиард галлон ус хаягддаг гэсэн тооцоо байна
2. Ихэнх америкчууд усны 30% -ийг ногоон байгууламжийн усалгаанд ашигладаг байна.
3. Ногоон байгууламж, гадаад талбайд 1 минут тутамд 10 галлон усыг, 150 галлон усыг гудамж талбайг цэвэрлэх зориулалтаар хэрэглэдэг байна.
4. Нийт усны ¼ -ийг хүнсэнд хэрэглэдэггүй ногоог тарьж ургуулахад ашигладаг байна.





МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГОД ТУСТАГДСАН УС ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ТАЛААРХИ ЗОРИЛТ ХЭРЭГЖИЖ БАЙНА

БХБЯ-ны Орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга: **Р.Эрдэнэцэцэг**

XXI зууны дэлхий нийтийн анхаарал татаж байгаа гол асуудал бол хүн амыг ундны усаар хангах, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг дээшлүүлэх явдал юм.

2000 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагаас хүний хамгийн чухал эрх нь усаар хангагдах хэмээн тунхагласан бөгөөд үүнтэй холбогдуулан улс орон бүр хүн амынхаа ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг дээшлүүлэх зорилт тавьсан.

Монгол Улсын Их Хурлын 2008.01.31-ний өдрийн 13 дугаар тогтоолоор Мянганы хөгжлийн зорилтын хавсралтыг шинэчлэн баталж, **"2015 он гэхэд баталгаат ундны усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бууруулах"** зорилт дэвшүүлсэн билээ.

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан хүн амыг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:



1. Дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар хот, аймгийн төвүүдийн цэвэр, бохир усны шугам сүлжээг шинэчлэх, шинээр барих
2. Нийт аймгууд, томоохон суурин газруудын нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудыг цэвэр, бохир усны суурин болон зөөврийн лабораторитой болгох
3. Газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан байгуулахтай холбогдуулан 21 аймгийн төвийн инженерийн шугам сүлжээний зургийг программд оруулж, шинэчлэх
4. Усны зүй зохистой хэрэглээг хэвшүүлэх, хяналтыг сайжруулах зорилгоор аймгуудын нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудыг усны тоолуурын лабораторитой болгож, гол магистраль шугамуудыг эхний ээлжинд тоолууржуулах
5. Инженерийн байгууламж, шугам сүлжээний ашиглалтыг хариуцдаг байгууллагуудын санхүүгийн



болон техникийн чадавхи, менежментийг сайжруулах г.м ажлуудыг төлөвлөөд, хэрэгжүүлж эхлээд байна.

Сүүлийн жилүүдэд Засгийн газраас дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар хот, аймгийн төвүүдийн цэвэр, бохир усны шугам сүлжээг шинэчлэх, шинээр барих олон арван төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Зөвхөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ 2013 оныг 2012 онтой харьцуулахад 2 дахин өссөн байна.

Улсын 2013 оны төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх төсөл арга хэмжээний төлөвлөлтөөр 290 км орчим цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээг шинэчлэх, шинээр угсрах, 12 тооны цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэл, 16 аймгийн 60 худагт ус зөөлрүүлэх тоног төхөөрөмж, 23 аймаг, суманд усны тоолуурын лабораторийн тоног төхөөрөмж, 28 аймаг, сумын инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг бүрдүүлэх, 3 сумын төвийг шинэчлэх, 5 аймгийн төвд баригдах 1000 айлын орон сууцны инженерийн шугам сүлжээний ажлын зураг, төсвийг боловсруулах ажлууд хийгдэнэ.




Дээрхи ажлуудын зэрэгцээ Монгол Улсын хот, суурин газар /аймаг, нийслэл, сум, дүүрэг/-ын хүн амын ашиглаж байгаа өмчийн бүх хэлбэрийн шаардлага хангасан ба шаардлага хангаагүй унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэр, ариун цэврийн байгууламжийг хамруулан судалгааны ажлыг НҮБ-ын Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн Хамтарсан хөтөлбөрөөс санхүүжүүлэн, мэргэжлийн багаар гүйцэтгүүллээ. Энэхүү ажлыг хийхэд Үндэсний статистикийн хорооны даргын 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 182 тоот тушаалаар баталсан "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал", Хүн ам орон сууцны 2010 оны тооллогын (ХАОСТ) асуулга, асуулгын тайлбар, Зам, тээвэр, барилга, хот байгуулалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2012 оны 7 дугаар сарын 02-ний өдрийн 192/А-255 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг тодорхойлох аргачлал" -ыг үндэс болгосон юм.

1-р зураг. Шаардлага хангасан ус хангамжийн үйлчилгээ хүртэж байгаа хүн ам

Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн хүртээмж улсын хэмжээнд 37,3 хувь байгаа бөгөөд энэ нь мянганы хөгжлийн зорилтоос 2,3 хувиар доогуур байгаа юм. Мөн энэ 37,3 хувь бол аймаг хотын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар үйлчлүүлж байгаа дүнг дунджилсан тоо биш харин улсын хэмжээнд шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар үйлчлүүлж байгаа хүн амын эзлэх хувь юм. Үүнд хүн амын бараг тал хувь нь оршин сууж байгаа Улаанбаатар хот болон Орхон, Дархан, Говьсүмбэр аймгийн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ голлох үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал Улаанбаатар хот Орхон, Дархан, Говьсүмбэр аймгийн хүн амын 49,73-60,4 хувь нь шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ хүртэж байна. Харин ихэнх аймгийн хүн амын дөнгөж 20 хүртлэх хувь нь шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ хүртэж байна гэж дүгнэгджээ.

Судалгааны дүнгээс харахад шаардлага хангасан ус хангамжийн хүртээмж улсын хэмжээнд 78,4 хувь байгаа бөгөөд энэ нь мянганы хөгжлийн зорилтоос 18,4 хувиар илүү байгаа юм. Мөн энэ 78,4 хувь бол аймаг хотын шаардлага хангасан ус хангамжийн үйлчилгээгээр үйлчлүүлж байгаа дүнг дунджилсан тоо биш харин улсын хэмжээнд шаардлага хангасан ус хангамжаар үйлчлүүлж байгаа хүн амын эзлэх хувь юм. Үүнд хүн амын бараг тал хувь нь оршин сууж байгаа Улаанбаатар хот болон Орхон, Дархан, Говьсүмбэр аймгийн ус хангамжийн үйлчилгээ голлох үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал Улаанбаатар хот, Орхон, Дархан, Говьсүмбэр аймгийн хүн амын 92,4-99,5 хувь нь шаардлага хангасан ус хангамжийн үйлчилгээ хүртэж байна. Харин өөр бусад аймгийн тухайд авч үзвэл Дорноговь, Дорнод, Төв, Хэнтий, Сэлэнгэ, Өмнөговь, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн хүн амын 60-аас дээш буюу мянганы хөгжлийн зорилтод түвшнээс дээш хувь нь шаардлага хангасан усаар хангагдаж байна. Бусад 10 аймгийн хүн амын 60-аас доош хувь ялангуяа Баян-Өлгий аймгийн дөнгөж 15,9 хувь нь шаардлага хангасан ус хангамжийн үйлчилгээ хүртэж байна гэсэн дүн гарчээ.



5-р зураг. Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар үйлчлүүлж байгаа хүн ам


Цаашид хүн амын ус хангамжийг сайжруулах, стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулах, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг хариуцсан байгууллагуудын менежментийг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.



2012 оноос эхлэн нийт аймгууд, томоохон суурин газруудын нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудыг цэвэр, бохир усны суурин болон зөөврийн лабораторитой болгох ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар хийж байгаа бөгөөд энэ ажлыг гүйцэтгэснээр иргэдийг баталгаатай, стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангах, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамруулах, байгаль орчны бохирдлыг багасгах, хяналтыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой төдийгүй уснаас шалтгаалсан өвчлөл багасах хүртэл ач холбогдолтой гэж үзэж байна.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын хувьд цэвэр усны алдагдал харьцангуй өндөр хувьтай байгаа нь Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс хийсэн судалгаанаас харагдаж байна. Улаанбаатар хотын хэмжээнд ус олборлож, түгээх үйл ажиллагаа явуулдаг 30 гаруй байгууллагын усны алдагдал нь 2012 оны эхний хагас жилийн байдлаар 14.4 сая метр куб байгаа нь Улаанбаатар хотын иргэдийн 3 сарын ундны усны хэрэглээтэй тэнцэхүйц хэмжээтэй ус юм. Хөдөө орон нутгийн 20-иод байгууллагын хэмжээнд алдагдлын нийлбэр нь 4.3 сая шоометр байгаа бөгөөд хамгийн өндөр хувьтай нь 80.2%-тай Завхан аймаг байна.

НАА-Н БАЙГУУЛЛАГУУДЫН УСНЫ АЛДАГДАЛ 2012 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР (ХУВИАР)



Иймд усны зүй зохистой хэрэглээг хэвшүүлэх, хяналтыг сайжруулах зорилгоор аймгуудын нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудыг усны тоолуурын лабораторитой болгож, гол магистраль шугамуудыг эхний ээлжинд тоолууржуулах ажлыг 2013 онд үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний үнэ, тарифыг өөрчлөөгүйгээс 2012 оны эхний хагас жилийн байдлаар НААҮ-ний 33 компани 7.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаад байна. Ус хангамж, ариутгах татуургын системийн үйл ажиллагааны зардлын 40 гаруй хувийг цахилгаан эрчим хүчний зардал эзэлж байгаа бөгөөд эрчим хүчний үнэ нэмэгдэх тохиолдолд алдагдал нэмэгдсээр байна. Иймд алдагдлын хэмжээг бууруулж, үйл ажиллагааг хэвийн явуулахын тулд усны үнэ


бүрдлийн тогтолцоог шинэчлэх, усны одоо мөрдөгдөж байгаа тарифыг өөрчлөх зайлшгүй шаардлага тулгараад байна.

Газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн санг байгуулах ажлыг НҮБХХ-өөс санхүүжүүлэн, тоног төхөөрөмж нийлүүлэх, ажилтнуудыг сургасан бөгөөд үүнтэй холбогдуулан 21 аймгийн төвийн инженерийн байгууламж, шугам сүлжээний зургийг программд оруулж, шинэчлэх ажлыг үргэлжлүүлэн улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байна. Ингэснээр инженерийн байгууламж, шугам сүлжээний төлөвлөлт сайжирч, үр ашиггүй зарцуулалт буурах төдийгүй иргэд, аж ахуйн нэгжүүд салбарын холбогдолтой шаардлагатай мэдээллийг нээлттэй авах бололцоотой болно.



ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2013 ОНД ХИЙГДЭХ АЖЛЫН ТАЛААР

Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулинд заагдсан Барилга, хот байгуулалтын сайдын багцанд тусгагдсан 186.3 тэрбум төгрөгийн 118 төсөл, арга хэмжээнээс инженерийн байгууламж, шугам сүлжээтэй холбоотой 144.3 тэрбум төгрөгийн 76 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавина. Өнгөрсөн онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 67 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж байсан бол 2013 онд энэ дүн 46,4 % -иар өссөн байна.



- хөрөнгө оруулалт /58 төсөл/
- их засвар /1 төсөл/
- тоног төхөөрөмж /4 төсөл/


Тус салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийг:

Санхүүжилтээр нь авч үзвэл:

- а) Хөрөнгө оруулалт - шилжин хэрэгжих 26 439,7 сая төгрөгийн 26; - шинээр хэрэгжих 110 786,1 сая төгрөгийн 32 төсөл арга хэмжээ;
- б) Их засвар - шинээр хэрэгжих 550,0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ;
- в) Тоног төхөөрөмж - шинээр хэрэгжих 3 500,0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ;
- г) Зураг төсөл боловсруулах - шинээр хэрэгжих 3 055,0 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээ болно.

Ажлын төрлөөр нь авч үзвэл:

- а) Инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, өргөтгөл, шинэчлэл хийх, шинээр угсралтын ажил гүйцэтгэх - 58 732,1 сая төгрөгийн 53 төсөл, арга хэмжээ;
- б) Цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах, өргөтгөл, шинэчлэл хийх, шинээр угсралтын ажил гүйцэтгэх 41 382,5 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээ;
- в) Орон сууц, тохижилтын их засвар, шинэ угсралт - шинээр болон шилжин хэрэгжих 42 356,2 төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ;
- г) Үерийн далан, суваг байгуулах, зураг төсөл боловсруулах - шинээр болон шилжин хэрэгжих 1 860,0 төгрөгийн 3 төсөл арга хэмжээ болно.



- Инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл, шинэ угсралт, зураг төсөл боловсруулах /53 төсөл/
- Цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэл, шинэ угсралт, зураг төсөл боловсруулах /14 төсөл/
- Орон сууц, тохижилтын их засвар, шинэ угсралт /6 төсөл/
- Үерийн далан, суваг байгуулах, зураг төсөл боловсруулах /3 төсөл/

Дээрхи арга хэмжээг хэрэгжүүлсэнээр Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх боломж бүрдэх болно.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар нэлээд олон төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа боловч тэдгээрийн үр өгөөж тааруу байгаа тул аймаг, орон нутагт улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаад дотоодын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллах, үр өгөөжийг дээшлүүлэх олон түмэнд ил тод мэдээллэх тал дээр санал, санаачлагатай ажиллах цаг нь болсон гэж үзэж байна.



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

Тэгш, чанартай, найдвартай, хүртээмжтэй үйлчилгээг бүгдэд

Танилцуулга

2011 оны 10-р сарын 06-ны өдөр шинэчлэн баталсан "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль"-ийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 02 сарын 15-ны өдрийн 46, 05 сарын 30-ны өдрийн 183 дугаар тогтоолын дагуу "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл" үүсгэн байгуулагдсан билээ.

Зөвлөлийн үйл ажиллагаа нь "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль", "Өрсөлдөөний тухай хууль", Засгийн газрын 2012 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дүрэм"-ээр зохицуулагдах бөгөөд тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй хэрэглэгчийн төлөөлөл, салбарын мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий бие даасан, хараат бус хамтын удирдлагын байгууллага юм.

Зохицуулах зөвлөл нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлсэн зохицуулалтын болон үнэ, тарифыг хянан баталгаажуулах үйлчилгээний хураамж, сургалт сурталчилгаа, мэдээллийн орлого зэргээс санхүүжих

бөгөөд тухайн жилийн үйл ажиллагааны төсвөө Засгийн газраар батлуулж, гүйцэтгэлээ тайлагнадаг болно.

Тус Зөвлөл тухайн орон нутгийн онцлог, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, үйлчилгээний цар хүрээг харгалзан усны үйлчилгээний үнэ тарифыг ялгавартайгаар батлан мөрдүүлэх бөгөөд ингэснээр хүн ам, үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагыг эрүүл ахуйн стандартад нийцсэн цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ эрхэлдэг нийтийн аж ахуйн байгууллагуудын цаашдын үйл ажиллагааны доголдлыг арилгах, усны алдагдлыг бууруулах, санхүүгийн алдагдлыг багасгах улмаар Нийтийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тэдгээрт дэлхийн бусад орнуудын дэвшилтэт технологи, туршлагыг нэвтрүүлэх, олон улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллахыг үйл ажиллагааныхаа эрхэм зорилго болгон ажиллаж байна.

Мөн эрхлэх асуудлынхаа хүрээнд холбогдох дүрэм, журмыг батлан мөрдүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, тухайн хот, суурин газарт хүн амыг цэвэр усаар хангах үйлчилгээний тарифыг боловсронгуй болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх нь бидний тэргүүний зорилт болоод байна.

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН
АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Дипломат 95-10 тоот
Утас, факс: 70147447; цахим хуудас: www.wsrc.mn, и-мэйл: info@wsrc.mn

НИЙТИЙН АЖ АХУЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ ОЛГОНО.

Цэвэр ус олборлох, дамжуулах, түгээх, бохир ус татан зайлуулах, цэвэрлэх барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэн явуулдаг аж ахуйн нэгж, компани "Нийтийн аж ахуйн хууль"-ийн дагуу хуучнаар Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авдаг байсан. Шинэчлэн баталсан "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль"-ийн дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл шинээр байгуулагдан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх бүрэн

эрхийг 2012 оны 6 сараас хэрэгжүүлж байна.

Тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж, байгууллага нь тусгай зөвшөөрлийн суурь нөхцөл, шаардлагыг хангасан байна. Тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлэх аж ахуйн нэгж, байгууллага доорх бичиг баримтыг бүрдүүлнэ.

Үүнд:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд Гадаадын хөрөнгө оруулалтын газраас олгосон гэрчилгээний хуулбар



2. Аж ахуйн нэгж, байгууллагын сүүлийн улирлын санхүүгийн тайлан тэнцэл
3. Татварын байгууллагын тодорхойлолт
4. Аудитын дүгнэлт
5. Шинээр байгуулагдаж байгаа аж ахуйн нэгжийн хувьд зөвхөн эхлэлтийн баланс
6. Инженер, техникийн ажилтан нэг бүрийн диплом, гэрчилгээ, батламж, зөвлөх инженерийн гэрчилгээний хуулбар мэргэшсэн инженерийн мэргэшлийн зэргийн гэрчилгээний хуулбар
7. Мэргэжилтэй ажилчдын үнэмлэхний хуулбар
8. Машин механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар, тухайн орон нутгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын тодорхойлолт
9. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу төлбөр төлсөн баримт
10. Зохицуулах үйлчилгээний хөлс төлсөн баримт

НИЙТ 9 АЖ АХУЙН НЭГЖИД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОЖ, 10 АЖ АХУЙН НЭГЖИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СУНГААД БАЙНА.

"Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл" үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш нийт 9 удаа зохицуулах зөвлөлийн хурлыг хийгээд байна. Зохицуулах зөвлөлийн хурлаар ажлын төлөвлөгөө, дотоод журам, тусгай зөвшөөрөл олгох журам зэрэг зөвлөл болон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын цаашид даган мөрдөх дүрэм журам батлах, нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудад тусгай зөвшөөрөл шинээр олгох, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, усны үнэ тарифын тогтолцоог шинэчлэх, өөрчлөх, суурь үнэ тооцох ерөнхий аргачлал, УСУГ, аймаг, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагуудын үнийн өөрчлөлтийн

санал, Зохицуулах зөвлөлөөс оруулж байгаа тухайн нутаг дэвсгэрт мөрдөх цэвэр, бохир усны үнийн өөрчлөлтийн санал зэрэг асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна.

Энэ хугацаанд нийт 20 байгууллага тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулахаар өргөдлөө гаргасан бөгөөд "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль"-ийн 12.2.1-14-р зүйлийн дагуу 9 аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл шинээр олгож, 10 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байна.

Тусгай зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгжийг гүйцэтгэх ажлын төрлөөр нь доорх хүснэгтэд үзүүлэв.

№	Компани, аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрлийн төрөл												
		12.2.1	12.2.2	12.2.3	12.2.4	12.2.5	12.2.6	12.2.7	12.2.8	12.2.9	12.2.10	12.2.11	12.2.12	12.2.13
Тусгай зөвшөөрөл шинээр авсан аж ахуйн нэгж														
1	"Бор-Өндөр хөгжил" ОНӨААТҮГ													
2	"Чандмань Тал" ХХК													
3	"Булнайн Ар" ХХК													
4	"Блю Голд" ХХК													
5	"Тохилог шинэ ертөнц" ХХК													
6	"Урьдчилсан цэвэрлэх байгууламж" НӨҮГ													
7	"Роял Ойл" ХХК													
8	"Толгойт" ТББ													
9	"Хүч Сервис" ХХК													
Тусгай зөвшөөрлөө сунгуулсан аж ахуйн нэгж														
1	"Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ" ОНӨХК													
2	"Цант-Орхон" ХХК													
3	"Гангар орд" ХХК													
4	"Чандмань Увс" ХХК													
5	УБ төмөр замын Эрчим хүч, ус хангамжийн 2-р анги													
6	"Багануур Ус" НӨҮГ													
7	"Таван Өндөр" ХХК													
8	"Шим Ус" ОНӨААТҮГ													
9	"Тулга хотхон" ХХК													
10	"Чандмань Баянхонгор" ХК													



НҮБ-ЫН УС ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ МОН/08/302 ТӨСЛИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ДОНДОВЫН МӨНХБААТАР

Засгийн газрын 2009 оны 285 дугаар тогтооллын хавсралт
"Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам"-ын 5 дугаар хавсралт

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО
(2012 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр, төслийн нэр, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Биелүүлэх хугацаа	Хяналтанд авсан заалт	Хэрэгжилтийн явц	
				Тухайн жилд хийсэн ажлын явц (хувь)	Хөтөлбөр, төсөл хэрэгжсэнээс хойш хийсэн ажлын явц (хувь)
A	1	2	3	4	5
Төсөл					
	НҮБ-ын Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах МОН/08/302 төсөл /2008.07.16/	2008-2013	- Төсөл хэрэгжиж буй аймаг, сумдын булаг шандыг хамгаалж тохижуулах, сумын төвийн хамгаалалтын бүс барих, хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах	· Төсөл хэрэгжиж буй 4 аймгийн 12 сумын 17 булаг шандыг хамгаалж тохижуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Говь-Алтай аймгийн Баян-Уул, Бигэр, Төгрөг сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүс барих ажлыг хийж гүйцэтгэсэн. Говь-Алтай аймгийн Баян-Уул сум, Баянхонгор аймгийн Шинэжинст сум, Өмнөговь аймгийн Булган суманд "Хуванцар хог хаягдал бутлах, хайлах, пресслэх бага хүч чадлын тоног төхөөрөмж" хүргүүлсэн.	100%
			-Ажлын томилолт зохион байгуулах	· 8 дугаар сарын 13-18-ны өдрүүдэд Ховд аймгийн Зэрэг, Дөргөн, Мянгад, Манхан сумдад 2 хүний бүрэлдэхүүнтэй ажлын баг томилолтоор ажилласан. Энэ үеэр "Хуванцар хог хаягдал боловсруулж, түүхий эд бэлтгэх, дахин ашиглах" сэдэвт сургалт зохион байгуулсан.	100%
				· 10 дугаар сарын 16-18-ны өдрүүдийн хооронд Ховд аймгийн Зэрэг, Манхан сум, 12 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд Говь-Алтай аймгийн Баян-Уул, Бигэр, Тонхил суманд хийгдсэн булаг шандны хамгаалалтын ажлыг газар дээр нь биечлэн үзэж, хүлээж авах ажлыг тус тус зохион байгуулсан.	100%
				· Гүйцэтгэгч ажлын иж бүрэн зураг төсөл боловсруулж, экспертизийн дүгнэлт гаргууллаа.	100%
			- Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын төвийн нийгмийн үйлчилгээний барилгуудын дотор цэвэр, бохир усны шугам сүлжээ, холбогдох гадна шугам сүлжээ болон цэвэрлэх байгууламж барих иж бүрэн ажлын зураг төсөл, төсөв боловсруулах		



			<p>боловсруулах</p> <p>-Ховд аймгийн Зэрэг сумын төвийн төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, ЦБ-ийн барилга угсралтын ажил</p>	<p>· Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын тендер зарлаж, шалгаруулсан. НҮБ-ын Нью-Йорк дахь төв оффисоос хариу хүлээж байна.</p>	70%
	НҮБ-ын Ус хангамж, ариун эврийн байгууламжийн Хамтарсан хөтөлбөр /2010.05.28/		<p>-Ажлын томилолт зохион байгуулах</p>	<p>· 4 дүгээр сарын 23-ны өдрөөс 5 дугаар сарын 5-ны өдрүүдэд Төсөл хэрэгжиж буй 4 аймгийн 12 суманд ажлын томилолт зохион байгуулсан. Энэ үеэр цаашид хамтран хэрэгжүүлж болох жижиг төслүүдийг тодорхойлж, төслийн гүйцэтгэлийн биелэлттэй танилцаж, дахин ашиглагдах хог хаягдлын талаар холбогдох мэргэжлийн болон орон нутгийн иргэдэд сургалт орсон. 11 дүгээр сарын 1-8-ны өдрүүдийн хооронд дараагийн ажлын томилолтыг 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийсэн. Ажлын томилолтоор хамгаалж, тохижуулсан булаг шандны ажлыг хүлээж авах, Өмнөговь аймгийн Булган суманд хийгдэх 3 талт гэрээ байгуулах, хүлээлгэж өгсөн тоног төхөөрөмжийн ашиглалтыг хянах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>	100%
			<p>-Өмнөговь аймгийн Булган сумын төвийн ус хангамжийн барилга угсралтын ажил</p>	<p>· Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын тендер зарлаж, шалгаруулсан. Гэрээг байгуулж, барилгын ажилд шаардагдах материалын худалдан авалтыг эхлүүлсэн.</p>	100%
	НҮБХХ-ийн Ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн Засаглал, сурталчилгаа, удирдлагыг сайжруулах төсөл /2010.05.31/		<p>Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах боловсон хүчин</p>	<p>1. Ажлын байрны талаар:</p> <ul style="list-style-type: none"> • Хамтын ажиллагаа, хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн • Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн • Үндэсний хяналтын инженер /2/ • Олон улсын хяналтын инженер 	100%
			<p>Сургалт, семинар, ажлын томилолт зохион байгуулах</p>	<p>2. Сургалт-аялал, ажлын томилолт, уулзалт, семинар зохион байгуулах ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • 3 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд “Төсөлд хамрагдаж буй сумдад 2012 онд төлөвлөсөн үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, чадавхийг бэхжүүлэх, оролцоог хангах нь” сэдэвт сургалт. /Оролцогчдын тоо: 30/ • 4 дүгээр сарын 19-ний өдөр “МХЗ 16-д нийтийн аж ахуйн салбарын оролцоо” сэдэвт уулзалт ярилцлага. /Оролцогчдын тоо: 61/ • 10 дугаар сарын 26-ны өдөр “Бага хүч чадлын цэвэрлэх байгууламж. Техникийн ерөнхий шаардлага” сэдэвт сургалт. /Оролцогчдын тоо: 68/ 	100%



			-Ус цахилгааны хэмнэлттэй бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа хийх, каталоги болон гарын авлага боловсруулах, Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн судалгаа хийх, альбом боловсруулах	3. УХАЦБ-ийн үйлчилгээний талаар: · Зөвлөхүүдийг сонгон шалгаруулж, ажлыг гүйцэтгэсэн.	100%
			-“Шаардлага хангасан ба хангаагүй ус хангамж, ариун цэврийн байгууламжийн тоон мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан газрын зураглал гаргах”	· Зөвлөхийг сонгон шалгаруулж, ажлыг гүйцэтгэсэн.	100%
			- УХАЦБ-ийн мэдээллийн нэгдсэн санг өргөжүүлэх зурган мэдээллийн санг бий болгох	· Зөвлөхийг сонгон шалгаруулж, ажлыг гүйцэтгэж байна.	100%
			- Өрхийн судалгааны сургалтын материал боловсруулах	· УХАЦБ-ийн хүртээмжийн үнэлгээний арга зүй, аргачлалд үндэслэн өрхийн судалгааны сургалтын материал боловсруулах ажлын хүрээнд гарын авлага боловсруулах зөвлөхийн гэрээ хийгдэж, боловсруулсан.	100%
			- ISO 24511:2007, ISO 24512:2007 болон EN 12255-1,4,6,7,10,11 боловсруулах	· ISO 24511:2007, ISO 24512:2007 болон EN 12255-1,4,6,7,10,11 стандартуудыг 1:1 харьцаатайгаар орчуулан Монгол улсын хөрсөнд буулгах ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
			- МХЗ-д тусгагдсан ус хангамж, ариун цэврийн байгууламжтай холбоотой зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	· МХЗ-д тусгагдсан ус хангамж, ариун цэврийн байгууламжтай холбоотой зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ЗТБХБ (хуучин нэрээр)-ын сайд Д.Дашдорж, БОАЖ (хуучин нэрээр)-ийн сайд Д.Цогтбаатар нар хамтран баталж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна.	100%
			- Санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулах	· 2 дугаар сарын 6-ны өдөр ЗТБХБЯ (хуучин нэрээр), НҮБХХ-ийн хооронд хамтын ажиллагааг өргөжүүлэх тухай Санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулсан.	100%
			- Гарын авлага боловсруулах	· “50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын цэвэрлэх байгууламжийн стандартыг нэвтрүүлэх нь” гарын авлагыг боловсруулах сургагч багш нарыг шалгаруулж, гарын авлагыг боловсруулсан.	100%

ОНЫ ОНЦЛОХ 1 АЖИЛ



НЭГ. Байгууллагын хэмжээнд 2012 оныг "Ажилтнаа хөгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орчинг сайжруулах" жил болгон зарлаж мэргэжлийн ажилчдыг бэлтгэх зорилгоор "Усны соёлын төв"-ийг ашиглалтанд хүлээн авч мэргэжил олгох сургалтуудыг зохион байгуулж нийт ажилтнуудын 37,2%-ийг эзэлж буй ус түгээгч нарыг мэргэжилтэй болгох зорилт тавьж сургалтанд 664 ус түгээгч, насосны машинчийн мэргэжил олгох сургалтанд 59 хүн, цэвэр бохир усны хоолойн засварчингийн мэргэжил олгох сургалтанд 4 хүн, тоног төхөөрмжийн засварчны мэргэжил олгох сургалтанд 8 хүн хамрагдаж мэргэжлийн батламж олгосон.



/зураг 01/

ХОЁР. Нэрэмжит жилийн хүрээнд ажлын байран дахь орчин нөхцлийг сайжруулах үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, мэргэжлээс шалтгаалах өвчлөл, бусад эрсдлээс хамгаалах зорилго тавин ажиллаж, ямар нэгэн осол гаргалгүй ажиллаа.

ГУРАВ. 2012 оныг Архи тамхигүй хамт олон ажлын байр, архидалтгүй хамт олон болох зорилт дэвшүүлж ажилласнаар Баянзүрх дүүргээс зохион байгуулсан "Хорт зуршилгүй хамт олон" болзолт уралдаанд Нэгдүгээр байр, Нийслэлийн эрүүл мэндийн газраас зарласан уралдаанд "Тамхигүй орчин бүрдүүлсэн хамт олон"-оор шалгарлаа.



/зураг 02/

ДӨРӨВ. Ундны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн хилийг тогтоосон солбицлын дагуу хамгаалалтын хашлагыг нийт 10,5 км газарт, хашааг "Олимп" хорооллын шинэ замын урдуур 1,45 км-д хийсэн. Хамгаалалтын бүс рүү нэвтрэхийг хориглосон анхааруулсан тэмдэг 60ш, эх үүсвэрүүдийг хамгаалалтын заагийн шон 10 ширхэгийг тус тус байрлуулсан. Ариун цэврийн бүсийн хамгаалалтыг сайжруулах зорилгоор Төв станцын хамгаалалтын бүс гүний худгуудад 53, Дээд эх үүсвэрт 1, Хар усан тохойд-2, Үйлдвэрт-1 хяналтын камер тус тус байрлуулсан.



/зураг 04/



/зураг 03/

ТАВ. Улаанбаатар хотын бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан гэр хорооллын усан хангамжийг сайжруулах, усны зүй зохистой хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор 2012 онд Голландын "VITNESS" компанийн хөрөнгөөр ЗУХА-ны 4 УТБ, шинээр 4 УТБ-г төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг хийн гүйцэтгэсэн. Гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж, төсвийн байгууллагуудын хүсэлтээр төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг жил бүр хийдэг бөгөөд тайлант онд хүсэлт гаргасан 15 хэрэглэгчийг холбож 2001 оноос хойш өссөн дүнгээр 346 хэрэглэгчийг холбож ус хангамжийн хүрэлцээ, чанарыг сайжрууллаа.



/зураг 08/

ЗУРГАА. Чех улсын буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотын ундны эх үүсвэр болох Төв станцын гүний худгуудын ажиллагааг сэргээх, гүний худгуудын усны ундарга түвшинг нэмэгдүүлж, шинэ техник технологийг нэвтрүүлэх төслийг 2011-2013 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж 2012 онд Төв станцын 36 гүний худгийн усны ундарга ба түвшинийг нэмэгдүүлэх ажлыг хийж цооногуудыг лайдаж, механик, химийн цэвэрлэгээ, угаалга, шавхалтуудыг хийж, дээж авч шинжлүүлэх, камераар цооногийн зураг авч, видеобичлэг хийж, баримтжуулах, насосыг суурилуулах зэрэг ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Энэ ажлын үр дүнд дээрхи худгуудын усны ундарга 15-20% дээшилсэн, худгийн түвшин 1,2-2,5м-ээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Төслийн энэ оны төлөвлөгөөний биелэлт 102,5 %- тай байна.

ДОЛОО. Япон улсын JICA олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас Гачуурт тосгоны дээд хэсэгт усны шинэ эх үүсвэр барих төслийн ажил 2011-2014 онд хэрэгжихээр төлөвлөгдөж энэ онд 21 гүний худгийн цооногуудыг өрөмдөж, ф 700 мм-ийн голчтой цэвэр ус дамжуулах гол 9,2 шилээр хүчитгэсэн нийлмэл пластик шугам, ф 500 мм-ийн голчтой салбар шугам 0,9 км ширмэн салбар шугам угсарсан. Мөн 15,17,19,21-р гүний худгийн барилгын суурийн угсралтын ажлыг хийж дуусгасан.

/Зураг06/



НАЙМ. Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөрийн хүрээнд Яармагийн шинэ хорооллын усан хангамжийг барих ажлын нээлтийг БНСУ-ын Койко олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хийж, энэ ажлын хүрээнд ф 6м-ийн гүний худаг 2-ийг 30-32 м өрөмдөж, цэвэр усны шугам 1,2 км угсарч, усан сан, дамжуулан шахах станцын барилга барих ажил 60 орчим хувийн гүйцэтгэлтэй байна.



/ зураг 07/

ЕС. Нийслэлийн боловсролын газартай хамтран ерөнхий боловсролын 9-11 дүгээр ангийн сурагчдын дунд Ус-эрүүл мэнд, Ус-байгаль орчин, Ус-хүний амьдрал сэдэвт илтгэлийн уралдаан, нийслэлийн цэцэрлэгийн ахлах бүлэг, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд Ус –амьдрал сэдэвт гар зургийн уралдаан, ОСНААУГ-ын харьяа орон сууцны компаниуд болон хувийн орон сууцны компаний усны инженерүүдийн дунд "усыг зүй зохистой хэрэглэх" эссэ бичлэгийн уралдаан, Баянголын ОУХАТ, Олонлог сургультай хамтарсан хөгжөөнт өдөрлөг зэргийг зохион байгууллаа. Мөн "Дусалхүүд тохиолдсон адал явдал" комиксын 9,10-р цувралыг гаргаж, байгууллагын сүлд дуу "Чандмань-Эрдэнэ", "Дусалхүү" дуунуудыг клип хийлгэж нийтэд сурталчилсан. Эдгээр ажлуудыг хэрэгжүүлснээр сургуулийн болон цэцэрлэгийн насны хүүхэд багачууд, хэрэглэгчдэд усыг хэмнэлттэй зарцуулах сэтгэлгээг төлөвшүүлэхэд түлхэц болсон гэж үзэж байна.



/ зураг 09/

АРАВ. Жил бүр Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас зохион байгуулдаг ТОП-150 аж ахуйн нэгж байгууллагаар, Монголын татварын албаны дээд шагнал "Хөх дэвтэр", НДЕГ-ын 70 жилийн "ТОП-70 шимтгээл төлөгч" байгууллага, Нийгмийн даатгалд даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах Тэргүү- Оюу нийгэмлэгийн "Монголын төлөө" цомоор тус тус шагнагдсан.



/зураг 10/



МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНООС ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БАЙГАА СУРГАЛТ СЕМИНАР

1. МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО, "ЦЭГЦ ТӨВ БОГД АУДИТ" ХХК-тай хамтарч 2013 оны 01 дүгээр сарын 14-өөс 18-ны өдрүүдэд 5 хоног "Эд хариуцагч"-дын сургалт зохион байгууллаа. Тус сургалтанд хот, орон нутгийн 7 компанийн эд хариуцагч хамрагдсан бөгөөд сургалтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулж мэдлэг олголоо.



2. МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО, УДИРДЛАГЫН АКАДЕМИТАЙ ХАМТАРЧ 2013 онд сар болгон "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ" сэдэвт сургалт семинарыг Улаанбаатар хотын хувийн хэвшлийн орон сууцны компанийн захирлуудад зохион байгуулахаар болсон, 2013 оны 01 дүгээр сарын 26, 2013 оны 02- дугаар сарын 26-ны өдрүүдэд "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ" сэдэвт сургалтыг УСУГ-н сургалтын төвд зохион байгуулсан бөгөөд компанийн захирлууд идэхитэй оролцлоо.



3. "МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО"-оос "Эрүүл мэнд, цэвэр агаар" сэдэвт уулзалтыг 2013 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр "ГЕО МАНДАЛ" жуулчны баазад Улаанбаатар хотын 13 компанийн захирлын бүрэлдэхүүнтэйгээр нэг өдрийг цэвэр агаарт сайхан өнгөрүүлээд ирлээ.



4. МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО, УСУГ-н сургалтын төвтэй хамтарч 2013 оны 02 дугаар сарын 04-08-ны хооронд 5 хоногийн "ЦАХИЛГААНЧДЫН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ" чадавхижуулах сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтанд сүүлийн үеийн шинэ техник технологитой танилцаж, орчин үеийн тоног төхөөрөмж дээр онол практик хослуулж сургасан бөгөөд, мэргэжлийн зөвлөх инженерүүд хичээл заалаа.



5. МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО, "ЦЭГЦ ТӨВ БОГД АУДИТ" ХХК-тай хамтарч 2013 оны 03 дугаар сарын 04-өөс 08-ны өдрүүдэд 5 хоног "Нягтлан бодогч"-дын сургалт зохион байгууллаа. Тус сургалтанд Улаанбаатар хотоос 3, орон нутгаас



11 компанийн Нягтлан бодогч хамрагдаж "НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МАНДАХ" Дээд сургуулийн багш нар заасан бөгөөд сургалтанд хамрагдсан нягтлангууд маш өндөр сэтгэгдэлтэй буцлаа.



6. МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО, "ДАРХАН УС СУВАГ" ХК-тай хамтарч 2013 оны 02 дугаар сарын 26-с 3 дугаар сарын 01-ны өдрүүдэд "АЙМГУУДАД ЦЭВЭР БОХИР УСНЫ ИТГЭМЖЛЭГДСЭН БОЛОН ЗӨӨВРИЙН ЛАБОРАТОРИ

БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН СУРГАЛТ"-ыг зохион байгууллаа. Тус сургалтанд нийт 21 аймгийн 40 лабораторийн ажилтан, мэргэжилтнүүд суралцаж нийлүүлэгдэж байгаа шинэ техник технологитой танилцаж, орчин үеийн тоног төхөөрөмж дээр онол практик хослуулж суралцлаа.



7. МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО, УСУГ-н сургалтын төвтэй хамтарч 2013 оны 03 дугаар сарын 13-18-ны хооронд 6 хоногийн "УДДТ-ийн МАШИНИСТЫН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ" чадавхижуулах сургалтыг зохион байгууллаа. Тус



сургалтанд ПОЛИТЕХНИКИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН багш хичээл зааж, тус сургуулийн дадлагын танхим, УДДТ-дэд дадлага хийх сүүлийн үеийн шинэ техник технологитой танилцаж, орчин үеийн тоног төхөөрөмж дээр онол практик хослуулж сургалаа.



УСУГ-ЫН СУРГАЛТЫН ТӨВИЙН МЭДЭЭЛЭЛ

Дэлхийн усны өдөрт зориулан гаргав
Сургалтын инженер Т. Батцоож
/Сургалтын төв/ 2013 он



Усанд амт гэж үгүй
 Усанд үнэр гэж үгүй
 Усанд өнгө гэж үгүй
 Усанд хэлбэр гэж үгүй
 Ус бол хамгийн энгийн мэт боловч
 Ус бол энэ хорвоогийн хамгийн гайхамшиг нь
 Ус бол хамгийн элбэг мэт боловч
 Ус бол энэ хорвоогийн хамгийн чухал нь
 Ус бол хамгийн эгэл мэт боловч
 Ус бол энэ хорвоогийн хамгийн нууцлаг нь
 Ус бол хамгийн үнэгүй мэт боловч
 Ус бол энэ хорвоогийн хамгийн үнэтэй нь

Ус нь амьдралын анхдагч
 Ус нь амьдралыг тэтгэгч
 Ус нь амьдралыг баясгагч
 Ус нь амьдралыг уртасгагч
 Уснаас бүх зүйл эхэлж
 Усанд бүх зүйл дуусдаг
 Уснаас зөөлөн нь үгүй боловч
 Уснаас хатуу нь бас үгүй
 Усанд мэдээлэл бий
 Усанд ухаан бий
 Усанд чадал бий
 Усанд энерги бий

УСУГ-ын Сургалтын төв дээр 2013 оны 1-р сарын 07-оос 30-ны өдрүүдэд Монголын мянганы сорилын сан-Мэргэжлийн боловсрол төслийн мэргэжил дээшлүүлэх дэд төслийн санхүүжилтээр Монголын барилгачдын холбоотой хамтран хот хөдөөгийн МСУТ-ийн 30 багш

нарт мэргэжил дээшлүүлэх чадавхижуулах сургалтыг дотор сантехник, гадна шугам сүлжээ чиглэлээр мэргэшүүлэх, МСУТ-үүдэд нийлүүлэгдсэн сургалтын стэнд дээр "Шинэ тоног төхөрөмж"-ийн сургалтууд явагдаж байна.



Дээрх сургалтаар онолоор олсон мэдлэгээ сэргээж, лабораторид хуванцар хоолойг холбох хэрэгслээр холбож, наадаг багажар наан сүүлийн үеийн техник технологийн шинэчилэл, сургалтын багаж тоног төхөөрөмжтэй танилцлаа.

УСУГ-ын Сургалтын төвийн инженер Ж.Түмэнцэцэг



ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧИЙГ ХЭРХЭН ХЭМНЭХ ВЭ ?

Орчин үед хүмүүс бүх л зүйл дээр хоол унд, хувцас хунар, амралтын үедээ ч мөнгө хэмнэхийг хичээх болж л дээ. Хувийн машинаар явдаг нь нийтийн тээвэрт, шилжиж суугаад бензиний мөнгөө хэмнэх, нийтийн тээврээр явдаг нь элдэв аргаар туулайчлахыг оролдох боллоо.

Тэгвэл өөр нэгэн хэмнэлт болох эрчим хүчний зарцуулалтаа хэрхэн бууруулах бэ?

Цахилгааны үнэ өсөөд байгааг бүгд л мэднэ. Гэвч жилээс жилд цахилгаан хэрэглэдэг ахуйн хэрэглээний шинэ зүйл нэвтрээд бид илүү их мөнгө төлөх боллоо.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ

Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн ,үзүүлж буй ажил, үйлчилгээний бүтээмжийг бууруулахгүйгээр эрчим хүчээ зөв зохистой хэрэглэхийг эрчим хүчний хэмнэлт гэж ойлгоно.

Эрчим хүчний хэмнэлтэд :

- Байгууламж , тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн эрчим хүч ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх
- Хаягдлыг багасгах
- Эрчим хүчний үр ашиггүй хэрэглээг багасгах зэрэг арга хэмжээнүүд багтана.

Яагаад эрчим хүчийг хэмнэх шаардлагатай юм бэ ? Яаж хэмнэх бэ?

Хэрвээ 1квтц эрчим хүч хэмнэвэл 0,5 кг нүүрс, 0.3 л нефть, 0.4 м3 хий үрэгдэхгүй хэмнэгдэх нь. Энэ нь танд өчүүхэн зүйл мэт санагдаж болно. Гэхдээ хэмнэлт ...сар , жилийн хэрэглээ, түүний төлбөр

- Хувь хүн
- үйлдвэр аж ахуй
- Улс орон Тэгвэл

Ахуй хэрэглээний хүрээнд хэрхэн хэмнэх бэ?

Юуны өмнө эрчим хүч хэмнэхийн ач холбогдлыг хэрэглэгч бүрт ойлгуулах . цахилгаан эрчим хүч хэмнэлтийн арга барилд сургаж, хэмнэх дадал зуршил тогтоох

1-р алхам

Шаардлагагүй гэрлээ унтраах, гэрээс гарахдаа бүх өрөө жорлонгийн өрөөгөө шалгаж гэрлийг унтрааж байх, Гэрийн цахилгаан хэрэглээний 15%-ийг гэрэлтүүлэг эзэлдэг. Үүнийг 50% хувь хүртэл хэмнэж болно. Эрчим хүчний хэмнэлттэй чийдэн худалдаж аваад гэртээ тавь. чийдэн авахдаа Хятадын зах дээрээс биш чанартайг нь

дэлгүүрээс нь ав. Зөвхөн нэг улайсах чийдэн сольсноор 100 кг нүүрс шатаахыг зогсоож 270 кг нүүрсхүчлийн хий (CO2) агаарт ялгарахгүй болно.Тодорхой зөв цэгт гэрлийн ойлт сайтай бүрхүүл ашиглах, хана нь цайвар өнгөтэй байх

Мэдээжээр хамгийн эртний эрчим хүч хэмнэх арга нь ухаалаг хэрэглээ буюу явахдаа "Гэрлээ унтраа" гэдэг байсан

2-р алхам

Хэрвээ компьютер дээр ажиллаж байвал дуу өсгөгчийг унтрааж байх, асаалттай нь орхигоор бол дууны өсгөгчөө салгаж байх

LCD дэлгэц нь электрон цацралтын дэлгэцээс 50% -аар бага энерги хэрэглэдэг.

3-р алхам

Орчин үеийн зурагт, хөгжим , зарим цахилгаан хэрэглэлд хүлээлтийн горимд жижиг гэрэл байнга асч байдаг. Иймээс төхөөрөмжөө бүрэн унтраах хэрэгтэй. Шинэ төхөөрөмж худалдан авахдаа хүлээлтийн горимдоо цахилгаан хэрхэн зарцуулахыг асуух хэрэгтэй.

4-р алхам


Зарим хүмүүс зурагтаа, хөгжимөө, радиогоо залгаж орхиод өөр ажил хийгээд явчихдаг. Энэ маягаар хоосон ажиллаад л байдаг.

5-р алхам

Зарим төрлийн цахилгаан хэрэглэлүүд:Дурын ахуйн хэрэглэлийг хэрэгцээнээсээ хамааруулан сонгон авах шаардлага гардаг. Албан тасалгаа цэвэрлэдэг болон, жижиг өрөө,тоос сорогч,7 кг хүртэл цагаан хэрэглэл угаадаг угаалгын машиныг цөөн хүнтэй айлд сонгох хэрэгтэй юу ?Ахуйн хэрэглээний төхөрөмжүүд улам бүр л эрчим хүчний хэмнэлттэй болоод байгаа.Цаашдаа ашиглах үедээ цахилгаан хэмнэх талаар олон дахин



ярьдаг.



Ахуйн хэрэглээний тоног төхөөрөмж нь цахилгаан хэрэглээгээрээ дараах ангилалд хамаарагддаг. Үүнд: EER (Energy Efficiency Ratio). Түвшин А,В,С – их хэмнэлттэйгээс илүү хэмнэлттэй, Түвшин Е, F, G – өндөрөөс маш их өндөр хэрэглээтэй. D – завсарын утга
Цахилгаан их хэрэглэдэг. ахуйн тоног төхөөрөмжүүд:



6-р алхам

Цахилгаан зууханд яаж цахилгаан хэмнэх бэ? Тэгш ёроолтой ширэм ашиглах, хэрвээ цай уух бол цахилгаан данхаа, ганцхан өөрөө цай уух бол кофе буцалгагчаа хэрэглэхээр олон төрлийн цахилгаан төхөөрөмжтэй байх. Халах ширэм бүрэн, бүтэн, хагарч цуурайгүй, гадаргуу нь цэвэрхэн байвал сайн халдаг. Хэрэгцээндээ зориулсан олон төрлийн сав суулгатай байх, эрчим хүч хэмнэе гэвэл халах ширэмнийхээ гадаргын хэмжээнд тохирсон сав суулга хэрэглэх, сав нь тагтай байх, Тагтай байх 3 дахин бага цахилгаан зарцуулдаг.

Савны ёроол нь тэгш, халах гадаргуу дээр нягт суусан байхгүй бол тэгш биш бол хутгах үед осол гарч болно. Хурдан буцалгагч ашиглавал эрчим хүч цаг хугацаа олон зүйлийг хэмнэдэг. Өөр нэгэн энерги хэмнэгч бол индукцийн цахилгаан тоноглол юм. Энэ тоноглол нь савны талбайн хэмжээгээр халдаг. Саваа авангуут хөрдөг. Халах гадаргаас бусад нь хүйтэн байдаг, дэвэрч асгарсан шингэн зүйлийн хиншүү хярвас үнэртдэггүйгээрээ онцлогтой. Харин зөвхөн өөрийн зориулалтын сав суулга шаарддаг

7-р алхам

Гэр байшингаа сайн дулаалах, салхижуулалтыг сайн хийх нь цахилгаан халаагуур, агааржуулалтыг олон дахин залгах шаардлага гарахгүй. Ер нь барилгын үндсэн хийц, хана, шал, дээврээр дулааны 20-80% нь алддаг гэж тооцдог. Цонхоо наахад л 40% хүртэл дулаан

алдагдалт буурдаг байна.

8-р алхам

Зурагт үзэхдээ радиогоор дууг нь сонсвол цахилгаан маш бага зарна. Ер нь зурагт үзэхдээ ном унших, спорт тоглоом тоглох, зугаалах, ногоо тариалан эрхлэх, зэрэг бусад идэвхтэй зүйлийг давхар хийхийг бодох хэрэгтэй юм.

Үйлдвэрлэлийн хүрээнд

Цахилгааны дэд өртөө дээрхи алдагдлыг бууруулах. Гүйдэл дамжуулагчийг зөв сонгох Цахилгаан ачааллыг тооцох, фазын ачааллыг тэнцүүлэх Трансформаторын хоосон явалтыг бууруулах, Олон жил ашиглагдсан трансформаторыг солих, Компенсацийн төхөөрөмж хэрэглэх, АҮК дээшлүүлэх г.м.

Цахилгаан дамжуулах агаарын шугамын тухайд

Утасны хөндлөн огтлолыг зөв сонгох, олон залгаасгүй болгоно. Гүйдэл дамжуулагчийн урт, дамжуулах цахилгаан чадал, хүчдлийн уналтыг оргил ачааллын цагаар бодож тооцоолох Хэмжилт, туршилтын дүнд цахилгаан ачааллыг жигдрүүлэх, хөнгөн цагаан ил утастай дамжуулагчийг СИП кабелиар солих

Дамжуулагч кабель, утсууд


Холбоос залгаас, контакт, муфт дээрхи хүчдэлийн алдагдлыг бууруулах.

Үйлдвэр цех, ажлын байранд

Эрчим хүчний хэмнэлттэй, бүтээмж эдэлгээ сайтай тоноглолоор хуучин хэсгийг солих, ажиллагсад эрчим хэмнэх, дадал зуршил олгох, эзэмшүүлэх, энерги хэмнэх шинэ техник, тоноглол нэвтрүүлэх, зөөлөн асаагч, давтамж хувиргагчийг хэрэглэх.

Цахилгаан хангамжийн сүлжээнд энергийн алдагдлыг бууруулах

Цахилгаан дамжуулах нүцгэн утсыг СИП утсаар солих, элэгдсэн хуучин тоног төхөөрөмжийг орчин үеийнхээр солих Үйлчилгээний чанарыг сайжруулах (үзлэг, цэвэрлэгээ, холболтыг шалгах) Кабелийн хуучин холболт дээрхи алдагдлыг арилгах, шаардлагатайг нь шинээр солих Реактив чадлын нөхөлт хийх, гадна гэрэлтүүлгийн хуучирсан чийдэн, гэрэлтүүлэгчийг орчин үеийн бага чадалтай гэрлийн урсгал, өгөлт багатай чийдэнгээр солих, дулааны эрчим хүчийг хэмнэх, дулааны алдагдалгүй барилга барих (Хаалга, цонхыг дулаалах гэх мэт) Мэдрүүл, датчик ашиглах юм.




ДАВТАМЖ ХУВИРГАГЧ АШИГЛАВАЛ

Энергийн нөөцийг 50% хүртэл хэмнэнэ. Төхөөрөмжийн эдэлгээг 30% хүртэл ихэсгэнэ. Төлөвлөгөөт засварын зардлыг 40% бууруулна. Гэмтэл саатлын тоо 80% хүртэл бууруулна. Бүтээмжийг 25%-иар өсгөнө. Шуугиан чимээ 50% буурна.

Хөдөлгөөний, гэрлийн, түвшингийн, дулааны, даралтын, энергийн, фото гэх мэт олон төрлийн (датчик) мэдрүүлийг ашиглана.

Насосны станцуудын удирдлага хяналтын бүрэн автоматжуулалтын систем



МУ-ЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР С.ОДГЭРЭЛ



ЦЭРЭНГИЙН ЧИМЭДХОРОЛ

Цэрэнгийн Чимэдхорол 1955 онд Завхан аймгийн Нөмрөг суманд төрсөн. ЗХУ-ын Свердловск хотын / тэр үеийн нэрээр/ Уралын Политехникийн дээд сургуулийг 1981 онд Усан хангамж, ариутгах татуургын инженер мэрэгжлээр төгссөн.

Ц.Чимэдхорол Барилга, барилга материалын үйлдвэрлэлийн яамны харьяа Нийгэм ахуйн барилга трестэд 1981 оноос Цэвэрлэх байгууламжийн барилга конторын даамал, ерөнхий инженер, трестийн үйлдвэр техникийн хэлтсийн дарга, нийтийн аж ахуйн барилга угсралтын чиглэлээр 1991 онд "Харз" ХХК-ийг байгуулж тус аж ахуйн нэгжийн захирлаар, 2002-2012 онуудад Төр, Засгийн Үйлчилгээ Аж Ахуйг Эрхлэх Газарт сантехникийн инженерээр оноос тус тус ажилласан. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж, Хар усан тохойн усан хангамжийн барилга байгууламж, Цэвэр усны дээд эх үүсвэрийн шугам сүлжээ, холбогдох барилга байгууламж, Буянт-Ухаагийн цэвэрлэх байгууламж, Дархан, Сайншанд, Зуунмод, Улиастай, Мандалговь, Сүхбаатар, Баруун-Урт хотын хотын цэвэр, бохир усны шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийг барьж байгуулах ажлыг удирдан ажиллаж гол гол техникийн шийдлүүдийг гаргахад биечлэн оролцож, Төв аймгийн Зуунмод, Багануур хот, Сэлэнгэ амийгийн Сүхбаатар хот, Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын болон хэд хэдэн амралт сувилалын газрын цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулсан. "Бага хүчин чадлын цэвэрлэх байгууламж"-ийн давтан хэрэглэх зургийн

1-Г1.907.9 ; 2-Г2.907.9 цомгуудыг боловсруулсан. Төрийн ордны халаалт, агаар сэлгэлт, цэвэр бохир усны системийг орчин үеийн техник, технологиор иж бүрэн шинэчлэх ажлын техник эдийн засгийн үндслэлийг санаачлан боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг хариуцан хийлгэсэн. 2005-2008 онд " Их эзэн Чингис хаан " хөшөө, "Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборын сантехник, агааржуулалтын системийн угсралт, тоноглолын ажилд захиалагчийн хяналт тавьж гүйцэтгүүлсэн. Барилгын салбарын зөвлөх инженерийн цол зэрэгтэй.

АЙЛ ӨРХ, АЛБАН БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАГДСАН БАГА ХҮЧИН ЧАДЛЫН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ХИЙГДЛЭЭ

Монгол улсын Засгийн газар, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд НҮБХХ, НҮБХС, НҮБХАС, ДЭМБ хамтран 2008 оноос "НҮБ-ын Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн Хамтарсан хөтөлбөр"-ийн хүрээнд "НҮБХХ-ийн Ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн Засаглал, сурталчилгаа, удирдлагыг сайжруулах" төслийг хэрэгжүүлж Монгол Улсын Засгийн газарт Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-д дэвшүүлсэн Баталгаат ус хангамж, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжийн зорилтуудад хүрэхэд дэмжлэг,

туслалцаа үзүүлэх зорилгоор айл өрх, албан байгууллагын хэрэгцээнд зориулсан бохир усны "Бага хүчин чадлын цэвэрлэх байгууламж"-ийн давтан хэрэглэх зургийн хоёр цомгийг одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Барилгын норм ба дүрэм, стандартуудын шаардлагад нийцүүлэн боловсруулж гаргах ажлыг гүйцэтгэлээ. Энэхүү цомгуудыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны тушаалаар баталгаажуулан 1-Г1.907.9 ; 2-Г2.907.9 гэсэн шифртэйгээр Хууль зүйн яаманд албан ёсоор бүртгүүлэн та бүхний хэрэгцээнд толилуулж байна. Хэдийгээр манай

улсад цэвэрлэх байгууламжийн олон төрлийн дэвшилттэй технологи, тоног төхөөрөмж нэвтэрч байгаа ч айл өрх, жижиг албан байгууллагын хүрээнд ашиглалтын нарийн төвөгтэй ажиллагааг явуулахад хүндрэлтэй байдгаас урьд өмнө өндөр үнэ өртгөөр барьж байгуулсан олон цэвэрлэх байгууламжууд ашиглагдахаа больсон байна. Та бүхэнд толилуулж буй энэхүү цомгууд нь маш энгийн, ашиглахад хялбар үнэ өртөг багатай байх зарчимд тулгуурлан боловсруулагдсан учраас ашиглалтын ажиллагаанд төдийлөн хүндрэл учрахгүй болсон гэж найдаж байна.



**БАЙГУУЛАМЖИЙН ХҮЧИН
ЧАДАЛ :**

**Цэвэрлэх байгууламжийн
хүчин чадал**

Айл өрхийн
хэмжээний
< 2 м3/хоног

Байгууллагын
хэмжээний
< 5 м3/хоног

Сумын төв, суурин
газрын хэмжээний
< 50 м3/хоног

НЭГ МАЯГИЙН ЗУРАГ

1-Р ПРОЕКТ:
ЭНГИЙН БАЙГАЛИЙН БИОЛОГИ ЦЭВЭРЛЭГЭЭ
ХҮЧИН ЧАДАЛ: 0.45; 0.75; 1.5; 3.0; 6.0; 12.0 м3/хоног

2-Р ПРОЕКТ:
БИОФИЛЬР
ХҮЧИН ЧАДАЛ: 1.5; 3.0; 6.0; 12.0; 25.0; 50.0 м3/хоног

ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОСОН ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛҮҮД

Септик

Хөрсөөр шүүх буюу хөрсөнд
шингээх энгийн байгалийн
биологи цэвэрлэгээ

Биофильтр-т зохиомол
биологи цэвэрлэгээ

Биофильтр-т зохиомол
биологи цэвэрлэгээг энгийн
биологи цэвэрлэгээтэй
хослуулсан хувилбар

НЭГ МАЯГЫН ЗУРАГ БОЛОВСРУУЛАЛТ

1. Элсэн болон элсэнцэр хөрстэй нөхцөлд шүүрүүлэх худаг, шүүрүүлэх талбай, шүүрүүлэх туннелийг септиктэй хослуулсан (0.5-12.0 м3/хоног хүчин чадалтайгаар)
2. Шавранцар хөрстэй (ус шингээх чадвар муутай) нөхцөлд 0.45-12.0 м3/хоног хүчин чадалтай шүүрүүлэх сувгийг септиктэй хослуулсан
3. Рашаан усны сав газар гэх мэт цэвэрлэгээний өндөр үр дүн шаардлагатай газруудад Септик → Биофильтр → Шүүрүүлэх талбай эсвэл шүүрүүлэх туннель гэсэн технологийн схемээр (1.5 - 12.0 м3/хоног хүчин чадалтайгаар) нэг маягын зураг боловсруулсан
4. Цэвэршүүлсэн усыг хөрсөнд нь шингээх боломжгүй нөхцөлд Септик → Биофильтр → Гадаргын ус хүлээн авагч (гол, мөрөн, сайр, гуу жалга гэх мэт) гэсэн схемээр (1.5 - 50.0 м3/хоног хүчин чадалтайгаар) нэг маягын зургийг боловсруулсан

**ХӨРСӨНД ШИНГЭЭЖ
ЦЭВЭРЛЭХ АРГУУД**

Септик



Шүүрүүлэх худаг

Шүүрүүлэх талбай

Шүүрүүлэх туннель

Хөрсөнд шингээж цэвэрлэх байгалийн биологи цэвэрлэгээний байгууламжуудыг элс, элсэнцэр, хайрган хөрстэй нөхцөлд хэрэглэнэ. Цахилгаан эрчим хүч зарцуулахгүй. Харин хэрэглэгчийн гол үүрэг бол жилдээ 1-2 удаа септикийн ёроолд хуримтлагдсан лагийг соруулан зайлуулж байх явдал юм. Септикт хуримтлагдсан лагийг цаг тухайд нь зайлуулж байх нь цэвэрлэгээний үр дүнг тогтмол сайн байлгах, байгууламжийн ашиглалтын хугацааг уртасгах гол хөшүүрэг болно.

ШҮҮРҮҮЛЭХ ХУДАГ




Шүүрүүлэх худаг нь 1-2 айлын буюу 3-10 хүний хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэрлэхэд зориулагдсан. Угсармал төмөр бетон цагираг ашиглан хийх, цутгамал бетон, хуванцар материалаар тус тус хийхээр зурагт тусгагдсан. Импортын материал шаардахгүй.



Шүүрүүлэх худгийн өртгийн баримжаа

Байгууламжийн хүчин чадал		мл/хоног	0.45(1 айл)	0.75(2айл)
Септикийн төрөл	Угсармал төмөр бетон цагираг	сая.төг	4.441	5
	Цутгамал бетон		4.556	4.9
	Хуванцар		4	5.834
	Импортын хуванцар		-	7.1

ШҮҮРҮҮЛЭХ ТАЛБАЙ




Шүүрүүлэх талбай нь 3-80 хүний хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэрлэхэд зориулагдсан. Септик-т механик бохирдлоос ангижирсан бохир усны биологийн бохирдлыг хөрсөнд нь шүүрүүлэх шингээх замаар цэвэрлэх арга юм. Хөрсөндөө шингэж байгаа учраас халдваргүйжүүлэлт хийх шаардлагагүй. Шүүрүүлэх талбай нь тодорхой хэмжээний талбай эзлэнэ.

Шүүрүүлэх талбайн өртгийн баримжаа

Байгууламжийн хүчин чадал		мл/хоног	0.45	0.75	1.5	3	6	12
Септикийн төрөл	Угсармал төмөр бетон	сая.төг	4.319	5.594	10.043	19.46	31.09	39.02
	Цутгамал бетон		4.461	5.487	10.403	18.904	26.86	34.803
	Хуванцар		3.903	6.421	15.296	32.638	46.18	79.48
	Импортын хуванцар		-	7.687	13.201	26.275	44.7	67.297

ШҮҮРҮҮЛЭХ ТУННЕЛЬ




Шүүрүүлэх туннель нь 3-80 хүний хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэрлэхэд зориулагдсан. Шүүрүүлэх талбайн нэг хувилбар бөгөөд усжуулах хоолойн оронд угсармал хуванцар, үйлдвэрийн хийцтэй туннель ашигласнаараа шүүрүүлэх талбайн хэмжээг эрс багасгаж буй орчин үеийн дэвшилтэт технологи юм.

Шүүрүүлэх талбайн өртгийн баримжаа

Байгууламжийн хүчин чадал		мл/хоног	0.45	0.75	1.5	3	6	12
Септикийн төрөл	Угсармал төмөр бетон	сая.төг	4.25	7.04	11.15	14	48.6	88.04
	Цутгамал бетон		4.4	6.94	11.5	23	44.38	83.85
	Хуванцар		3.84	7.87	16.4	36.74	63.7	128.53
	Импортын хуванцар		-	9.14	14.3	30.7	62.23	116.35


ХӨРСӨН ҮЕЭР ШҮҮЖ ЦЭВЭРЛЭХ АРГУУД



Хөрсөн үеэр шүүж цэвэрлэх байгалийн биологи цэвэрлэгээний байгууламжуудыг шавар, шавранцар, мөнхийн цэвдэгтэй, хадан зэрэг ус шингээх чадвар султай хөрстэй нөхцөлд хэрэглэнэ. Цахилгаан эрчим хүч зарцуулахгүй. Харин хэрэглэгчийн гол үүрэг бол жилдээ 1-2 удаа септикийн ёроолд хуримтлагдсан лагийг соруулан зайлуулж байх явдал юм. Септик хуримтлагдсан лагийг цаг тухайд нь зайлуулж байх нь цэвэрлэгээний үр дүнг тогтмол сайн байлгах, байгууламжийн ашиглалтын хугацааг уртасгах гол хөшүүрэг болно.



ШҮҮРҮҮЛЭХ СУВАГ





Шүүрүүлэх суваг нь 3-80 хүний хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэрлэхэд зориулагдсан. Шүүрүүлэх сувгийн ажиллагааны зарчим нь элс, хайрга, дайрга зэрэг шүүгүүр үеэр дамжуулан усыг шүүх ба шүүгдэн цэвэршсэн усыг халдваргүйжүүлэн газрын гадаргад гаргаж гол, мөрөн, сайр, жалганд нийлүүлэхэд оршино.

Шүүрүүлэх сувгийн өртгийн баримжаа

Байгууламжийн хүчин чадал		мл/хоног	0.45	0.75	1.5	3	6	12
Септикийн төрөл	Угсармал төмөр бетон цагираг	сая.төг	5.86	7.2	10.5	18.66	34.4	50
	Цутгамал бетон		6	7	10.87	18.1	30.18	45.78
	Хуванцар		5.44	8	15.76	31.83	49.5	90.46
	Импортын хуванцар		-	9.27	13.65	25.47	48	78.28

ЭЛС-ХАЙРГАН ШҮҮЛТҮҮР



Элс-хайрган шүүлтүүр нь шүүрүүлэх сувгийн нэг төрөл бөгөөд 3-80 хүний хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэрлэхэд зориулагдсан. Элс-хайрган шүүлтүүрийн ажиллагааны зарчим нь элс, хайрга, дайрга зэрэг шүүгүүр үеэр дамжуулан усыг шүүх ба шүүгдэн цэвэршсэн усыг тусгай саванд халдваргүйжүүлэн газрын гадаргад насосоор болон өөрийн урсгалаар нь гаргаж гол, мөрөн, сайр, жалганд нийлүүлэхэд оршино. Элс-хайрган шүүлтүүрийг нэг болон хоёр үет хэлбэрээр хийж болно.

Шүүрүүлэх сувгийн өртгийн баримжаа

Байгууламжийн хүчин чадал		мл/хоног	0.45	0.75	1.5	3	6	12
Септикийн төрөл	Угсармал төмөр бетон цагираг	сая.төг	5.5	6.78	9.18	16	29.22	45.22
	Цутгамал бетон		5.64	6.67	9.54	15.43	25	41
	Хуванцар		5.08	7.61	14.43	29.17	44.31	85.68
	Импортын хуванцар		-	8.87	12.33	22.8	42.83	73.5


БИОФИЛЬТРЭЙН ЗОХИОМОЛ БИОЛОГИЦЭВЭРЛЭГЭЭ

Биофильтрээр цэвэрлэх энэхүү байгууламж нь дараах технологийн хэсгээс бүрдэнэ.

Үүнд:


- А) 1. Сараалж бүхий худаг
2. Септик болон хоёр үет тунгаагуур
3. Биошүүлтүүр (Биофильтр)
4. Халдваргүйжүүлэх сан

БИОФИЛЬТРЭЭР ЦЭВЭРЛЭХ АРГУУД



- Б) 1. Цэвэршүүлэлтийн үр дүнг стандартад заасан хэмжээнээс (БХХ5"20мг/л; Умбуур бодис "35 мг/л) дээгүүр байлгах шаардлагатай, эсвэл цэвэршүүлсэн усыг илээр зайлуулах боломжгүй нөхцөлд септик болон биошүүлтүүрээр цэвэршүүлсний дараа шүүрүүлэх талбай, шүүрүүлэх туннель, шүүрүүлэх суваг, элс-хайрган шүүлтүүрээр дахин цэвэршүүлэх, хөрсөнд нь шингээх хувилбарыг хэрэглэж болно.

Биошүүлтүүрийг импортоор нийлүүлж байгаа бөгөөд цаашид өөрийн оронд үйлдвэрлэх асуудлыг судлаж байна.



Биофильтрийн гадаад байдал



Биофильтрийг шүүрүүлэх туннельтэй хослуулан хэрэглэсэн байдал ("МАК" ХХК-ний жуулчдын бааз-д)



"Хасумеговатт" ХХК-ний Металл эдлэлийн үйлдвэрийн цэвэрлэх байгууламж

Биошүүлтүүрт зохиомол биологи цэвэрлэгээний байгууламжийн өртгийн баримжаа

Байгууламжийн хүчин чадал		мл/хоног	1.5	3	6	12	25	50
Септикийн төрөл	Угсармал төмөр бетон цагираг	сая.төг	20	63	75.51	99	-	-
	Цутгамал бетон		20.44	62.53	71.3	94.8	-	-
	Хуванцар		25.33	76.26	90.6	139.47	-	-
	Импортын хуванцар		23.24	70	89.13	127.3	-	-
Хоёр үет тунгаагуур			-	-	-	-	130.4	235.5

Зөвлөх инженер Ц.Чимэдхорол



ЧЕХ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БАЙГАА ГҮНИЙ ХУДГИЙН ЦООНОГИЙН ШҮҮРИЙГ ЦЭВЭРЛЭЖ УНДАРГА САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН ТУХАЙ

Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар нь хотыг ундны цэвэр усаар хангахын тулд 4 эх үүсвэрийн 170 гаруй гүний худаг ашигладаг юм. Гүний худгийн цооног ашиглалтанд орсноос хойш 10-аас дээш жил ашигласан бол ундарга сайжруулах арга хэмжээ заавал авах ёстой гэсэн олон улсын жишиг байдаг юм билээ. Гэтэл манай байгууллагын ашиглаж байгаа гүний худгуудын 60 -аас илүү хувийг нь ашиглалтанд орсноос хойш 40-өөс дээш жил ашигласан ч нэг ч удаа гүний худгийн ундарга сайжруулах ажил хийгдээгүй байсан.

1958-1970 оны хооронд ашиглалтанд орсон Төв станцын гүний 60 худгийг 2011-2013 оны хооронд Чех улсын засгийн газрын буцалтгүй тусламжаар цооногийн шүүрийг цэвэрлэн лайдаж ундарга сайжруулах төсөл хэрэгжүүлж байгаа билээ. Энэ төсөл нь 2011 онд эхэлж Төв станцын нийт 68 худгийг задалж усны статик түвшин, цооногийн гүн, диаметр, цооногийн хийц, шүүрийн төрөл, шүүрийн хэсгийн урт, шүүрийн дотор талын байдал, шүүрийн нүхний зэврэлт, бөглөрөлт зэргийг камериар дурандаж видео бичлэг хийж буцааж угсарч ажиллуулсан ба эдгээр гүний худгуудаас гүний 60 худгийг нь сонгон авч уг төслийг хэрэгжүүлж байна.

1 гүний худгийн цооног цэвэрлэж ундарга сайжруулах ажилбар

- Эхлээд гүний худгийн мотор насосыг суглах
- Цооногийн диаметрт тохирсон троссон болон хуванцар сойзоор механик аргаар 4-6 цаг цооногийн шүүрийн нүх сүв, дотор талыг цэвэрлэх
- Цооногт хүнсний зориулалттай химийн бодис хийж / лемоний хүчил, перкись г.м/ 16 цаг болгоод дахиад механик аргаар 4-6 цаг сойздоно
- Цооногт релефт яндан угсарч цооногийн ус цэвэршлэл шавхалт хийнэ
- Цооногт шавхалтын насос тавьж 72 цаг тасралтгүй шавхалт хийнэ
- Шавхалт хийж байх үедээ цооногийн түвшний бууралт, цооногийн ундарга зэргийг хэмжиж тогтооно.
- Дараа нь усны дээжийг авч Усны төв лабораторит өгнө
- Дээж өгсний дараа шавхалтын насосыг суглаж цооногт дахин камер тавьж хийсэн ажлын үр дүнг шалгана
- Үр дүн муу байвал дээрх ажилбарыг дахин хийнэ.
- Усны дээж шинжилгээгээр ундны усны стандартын шаардлага хангасан байвал уг гүний худгийг буцааж угсарч усыг төвлөрсөн ус хангамжийн сүлжээнд ашиглана.

Мөн төсөл хэрэгжүүлж байхдаа цооногт унасан мотор насос, яндан хоолой, кабель утас, насос моторын эд анги зэрэг эд зүйлсийг авч байгаа бөгөөд цооногт релефт яндан угсарч шавхалт хийхэд цооногийн гүн 1-2 метрээр нэмэгдэж байна.

Энэ төслийг хэрэгжүүлснээр цооногийн ашиглалтын хугацаа уртсаж, цооногийн динамик түвшиний бууралт багасаж, гүний худгуудын хувийн ундарга 15-20% нэмэгдэж, усны чанар сайжирч, ажиллаж байгаа гүний худгийн тоо буурч цахилгаан эрчим хүч хэмнэж байна.



Цооногийг механик аргаар сойздож цэвэрлэдэг төхөөрөмж



Худгийн ундаргыг гурвалжин ус халиагуураар хэмжиж байгаа нь



Цооногийг камериар дурандаж байгаа нь

Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газрын Ус хангамжийн албаны ахлах инженер, Монгол улсын зөвлөх инженер Н.Батсайхан

Утас: 96000634

И-мэйл: batsaikhannn@yahoo.com



БОХИР УСЫГ ЦЭВЭРЛЭХ ХБНГУ -Н БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ БА ТЕХНОЛОГИЙН ДЭВШИЛ

Хураангуй

НҮБ-н судалгаагаар 2010 оны байдлаар нийтдээ 2,6 тэрбум хүн аруутгах татуургын ямар нэг сүлжээнд холбогдоогүй байна гэж тогтоожээ. Иймд НҮБ-н Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд дэлхий дээрх цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбогдоогүй хүн амын тоог 2015 он гэхэд 1,9 тэрбумаар бууруулах хэрэгтэйг заасан байна. 2010 онд Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас гаргасан тайланд ариутгах татуургын ямар нэг сүлжээнд холбох үйл явц удаашралтай, хангалтгүй явагдаж байгааг дурдсан байдаг. Герман улсын засгийн газраас үүнийг дэмжих, хэрэгжүүлэх үүднээс 2015 он гэхэд ХБНГУ-н бүхий л том, жижиг суурингаас гарах ахуйн бохир усыг төвлөрүүлэн татаж зөвхөн биологийн цэвэрлэх байгууламжаар цэвэршүүлэн байгальд нийлүүлэх хууль гарган, засгийн газраас бүрэн санхүүжүүлэн, төслүүдийг эхлүүлэн хэрэгжүүлээд байна. Өмнө нь Германд механик болон хагас биологийн цэвэргээний технологийг ашигладаг байжээ.

Оршил

ХБНГУ дээрх хууль нь олон түвшинд яригддаг. Европын Холбооны (ЕХ) удирдамжинд тухайлбал усны чанарын ерөнхий статусыг мөрдлөгө болгохыг заадаг. ЕХ-ний гишүүн орнууд эдгээр удирдамжийг үндсэн хуулиндаа тусган нутагшуулах хариуцлага хүлээдэг. ЕХ-ний 97/271/EGW дугаартай удирдамжинд бохир ус цэвэрлэх байгууламжуудын цэвэршүүлэлтийн бүтээмжийн хамгийн бага шаардлагыг тодорхойлж гаргасан байна. ЕХ-ний Усны удирдамж нь Европын усны хуулийн стандарт шиг усан орчны сайн чанарын статусыг хадгалах ба түүнд хүрэх зорилго агуулдаг. Эдгээр ЕХ-ний удирдамжуудын хэрэгжилтийг Герман улс Усны нөөцийн менежментийн хууль гэж нэрлэсэн. Энэ хуулийн тогтолцооны хүрээнд усан орчны хэрэглээнд зориулсан ерөнхий тодорхойлолт ба стандартуудыг гаргасан байна.

Түүнчилэн хуулийн дүрэм журамд мужын хүрээнд бага бохирдуулагчтай урсах болон цэвэршүүлэлтэндээ техникийн процессыг ашиглахыг шаардсан нөхцөлд усан орчин уруу бохир усыг урсаж болохыг зөвшөөрсөн байна. Эдгээр онцлог тодорхойлолтууд нь улсын /засгийн газрын/ захирамжын хүрээнд хийгддэг. Тухайлбал засгийн газрын захирамжын хүрээнд бохир усны захирамж мөрдөгдөх бөгөөд Германы нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр хэрэгждэг. Бохир усны захирамжинд бохир ус цэвэрлэх байгууламжуудыг оршин суугчдаас нь хамааруулж 5 ангилалд хувааж үзэх төдийгүй захирамжын дүрэм журамд хамгийн бага хэмжээгээр агуулагдах хэд хэдэн элементийн тухайлбал BOD, COD гэх мэт хязгаарлах хэмжээг зааж өгсөн. Томоохон бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлэлтийн бүтээмжинд илүү нарийн шаардлага тавьдаг бөгөөд Европын комиссынхон төвлөрсөн бус


бохир ус цэвэршүүлэх байгууламжийн хүчин чадал нь хамгийн ихдээ 5000 суугчын хаягдал бохир усыг цэвэрлэж байхаар заадаг байна.

Төв Азийн усны нөөцийн нэгдсэн менежмент: загвар бүс нутаг Монгол /MoMo/ төслийг Германы Боловсрол, Судалгааны яамнаас санхүүжүүлж, Монгол улсын Засгийн газар тогтвортой усны хэрэглээг хангах хүрээнд дэмжин хэрэгжүүлж байна. Төслийн гол зорилго нь загвар бүс болох Монгол орны усны нөөцийн нэгдсэн менежментийн (УННМ) стратегийн хөгжил ба хэрэгжилтийг хангахад оршино.

Бохир ус цэвэрлэх бага оврын байгууламж түүний технологи

1. SBR-н /Sequencing Batch Reactor/ процесс- SBR процессыг түүнчилэн "Дүүргэх – ба – Гаргах систем /Fill – and – Draw system/ гэж нэрлэх нь бий (1-р фото). Өөрөөр хэлбэл бүхийл үйл явц нь нэг реактор дотор явагддаг биологийн ба тунгаах сав нь тусдаа бохир усны байгууламжийн идэвхтэй үйл ажиллагааг хэлнэ. Түүнчилэн микробиологийн процесс нь энд явагддаг. SBR процессын гол давуу тал нь SBR-н эргэлтийн өөр өөр үе шатуудыг хялбархан өөрчилж болох өндөр технологит процесс юм.

SBR – бага оврын бохир ус цэвэрлэх байгууламж



Нийтлэг SBR-н эргэлт нь дараах үе шатуудаас бүрддэг.

Үүнд:

1. Орж ирж байгаа бохир усаар дүүргэх
2. Үйл явц нь дараах шат:
 - Агааргүй орчны
 - Anoxic шат
 - Агааржуулах шат
3. Лаг хуримтлагдах /Sludge settling/
4. Цэвэршүүлсэн усаа гадагшлуулах /Withdrawing treated water/

Орчин үеийн SBR системүүд нь 1970 оноос сайжруулсан. Өнөөдөр SBR нь өргөн хүрээнд ашиглагддаг болсон, тухайлбал Дублин хотын Рингсендийн бохир ус цэвэрлэх байгууламж, тэнд өдөрт 950.000 m³ бохир ус



цэвэршүүлдэг.

УННМ МоМо II төслийн нэг хэсэг болсон Монгол орны Дархан хотын шинэ төв цэвэрлэх байгууламжийн хэтийн төлөвлөлтөнд зориулсан туршилтын байгууламжийн үйл ажиллагаа, байгууламж, загварыг p2m компани хариуцан явуулсан. Туршилтын байгууламж нь SBR процессын тестед зориулан Дарханы бохир ус цэвэрлэх байгууламжийн талбайд байрладаг. Байгууламжийг 2011 оны 8-р сард суурилуулж, ашиглалтанд оруулан ажиллуулж байна.

Харин сул тал нь өөр өөр оролтоор нөхцөлдөх хэд хэдэн паралел процессууд нь SBR-н реактораар байнгийн бус байдлаар бохир ус урсдаг. Хэдий тиймч үүнийг SBR-н савны өмнө завсрын сав суурилуулсанаар хялбархан шийддэг. Энд байнгийн урсгалтай нэмэлт хэмжигдэхүүн болон хяналтын тоног төхөөрөмжийг шаарддаг процессын хяналт нь илүү комплекс системтэй харьцуулахад нэмэлт зардалтай байдаг. SBR-н процессыг дүгнэж хэлэхэд байнгийн урсгалтай системийг бодвол бага зайнд суурилагдах, шаардлагатай тохиолдолд процесс нь хувьсамтгай зэрэг тал бүрийн сонирхол татдаг процесс юм.

2. WSB® Цэвэршүүлэлт (Вирбэл/Швэбэбэтт/Биофилм) гэж нэрлэгдэх технолог нь хувийн, үйлдвэрийн болон хотын захиргааны хэрэглээнд зориулсан олон төрлийн загвараар ирдэг. WSB® цэвэр загварын цэвэршүүлэлтийн байгууламж нь 4-5000 хэрэглэгчийг хангадаг.




WSB® технолог буюу биофилмын зураг

WSB® Цэвэршүүлэлт нь цэвэр биофилм технологи бөгөөд нарийн технологитой шилжүүлэх материалыг ашигладаг (2-р фото). Урт хугацаанд өндөр чанартай цэвэрлэхэд зориулж үр ашигтай биофилмийг жижиг хэмжээний шилжүүлэх материалаар бий болгох бөгөөд түүн дээр том талбайг хамрах микроорганизмууд байдаг. Энэ нь тохиромжтой урсгалаар нөхцөлдөх бүрэн хэмжээгээр ялзрах процессыг дэмждэг. Бохир усны температур 4°C байх хүйтэн өвөл хялбархан ажилж чадах ба биологийн бүрэн WSB® процесс ч бас найдвартай явагдана. Энэ технолог нь урсгалын эсрэг талд /урсгал сөрж/ сайн ажилладаг. Жишээлбэл удаан хугацаанд ашиглагдаагүй үед тохиолддог өөрөөр хэлбэл хэрэглэгч амралттай байх тохиолдолд, мөн бага оврын ус цэвэрлэх байгууламжийг төлөвлөсөн хэмжээнээс бага хүнтэй байнга ашиглахад гэсэн энэ 2 тохиолдолд автолиз /autolysis/ явагддаг. Төслийн хүн амын тоо, бүтэц нь ойролцоо гэхдээ суурьших бүтэц нь өөр хоёр орон нутагт хэрэгжүүлэх боломжтой.

WSB® Цэвэршүүлэлтийн технологи нь эхний хэсэгт бохир бодисуудыг салгана. Хатуу (өтгөн) бодисууд газарт тунаж, хөнгөн бодисууд усны дээд хэсэгт хөвнө.

Энэ хэсэг (тасалгаа) нь лаг хадгалах үүрэг гүйцэтгэнэ. Усны ёроолд байрлах хоолойгоор ус дараагийн шат руу шилжинэ. Энэ усны ёроолд байрлах хоолой нь ойролцоогоор 50см-ын гүнд байрлана. Хөвөгч бодисууд болон лаг нь энэ хоолойгоор урьдчилгаа цэвэрлэгээ рүү буцаагдана. Биореактор- Биологийн бүрэн цэвэрлэгээ нь WSB® -н үйлдэл дээр суурилна. Биореакторт ойролцоогоор 50%-ын тусгай, өндөр зэргийн зөөгч материалыг оруулна. Зөөгч материал нь ойролцоогоор 8мм-н диаметртэй байна



Биофилмын бодит жишээ

Энэ зөөгч дээр бохир усны органик хэсгүүдийг тэжээл болгон авч, экологийн бодисын солилцооны бүтээгдэхүүн болгон хувиргах микроорганизмууд ургана. Энэ зөөгч материалыг урсгахгүйн тулд энэ хэсэгт (тасалгаа) онгорхойтой нарийн хоолой байрлуулсан байна. Микро биетүүдээс гарах шаардлагатай хүчилтөрөгчийг даралттай агаар сорж авна. Нягтаршуулагчийн тусламжтайгаар даралтат агаар нь биологийн цэвэрлэгээний шатны мембран (хальс) агааржуулагч руу орно. Нягтруулагч нь байгууламжийн гадна орших техникийн өрөөнд байрлана. Даралттай шланк бүхий хоосон хоолой энэ өрөө байгууламж хоёрыг холбоно. Нягтруулагчийг мөн техникийн өрөөнөөс удирддаг.

Дүгнэлт

ХБНГУ нь НҮБ-н Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд хууль гарган 2015 он гэхэд бүхий л том, жижиг суурингаас гарах ахуйн бохир усыг төвлөрүүлэн татаж зөвхөн биологийн цэвэрлэх байгууламжаар цэвэршүүлэн байгальд нийлүүлэх зорилттойгоор түргэн хурдацтайгаар энэ ажлыг гүйцэтгэж байгаа нь өөрийнх нь орны ард иргэдэд их таалагдаж энэ төсөлд иргэн бүр идэвхтэй оролцон дэмжиж ажиллаж байна. Мөн гадны улс орнуудын нилээд анхаарлыг татаж харилцан туршлага солилцон технологио нэвтрүүлэх хүсэл эрмэлзлэл ихтэй байгаа нь харагдаж байсан юм.

Монгол орны хувьд дээрхи технологитой ижил төстэй бага оврын цэвэрлэх байгууламжуудыг олон жилийн өмнөөс ихээр оруулж ирэн олон газарт суурилуулан ашиглаж эхэлсэн байгаа. Энэ байгууламжийн онцлог нь хол тээвэрлэн хүргэж ашиглахад хялбар, өртөг багатай, сум, сууринд тохиромжтой шийдэл болоод байна. Монгол-Германы МоМо төслийн хүрээнд хөрөнгө оруулан хэдэн жилийн өмнөөс эхлэн Дархан хотын сургууль, цэцэрлэг, гэр хорооллын бохир усыг зайлуулан цэвэршүүлэх зорилгоор төрөл бүрийн арга, техник, технологийг нэвтрүүлэн туршиж ажиллаж байгаа нь сайшаалтай ажил болсоор байгаа юм.

Ашигласан материал

1. BDZ-Төвлөрсөн бус бохир усны шийдэл, сургалтын хөтөлбөр Германы Лайфциг хот. 2011 он.




БОРООНЫ УС ЗАЙЛУУЛАХ ТУСТАЙ СИСТЕМ

1. RECHSAND Борооны усны цооног, зам дээрх борооны усыг шингээх систем

Энэхүү систем нь хот доторхи явган хүний зам болон авто машины зам зэрэгт зориулан борооны усыг хуримтлуулах эко-замын системийг гарган ирэхэд чиглэгдсэн болно.

Уламжлалт ус зайлуулах технологийг өөрчлөн шугамын болон хавтгай хэлбэрийн ус зайлуулах хэв маягийг хослуулан "БОРООНЫ УСЫГ ХУРИМТЛУУЛАН ШИНГЭЭН ЗАЙЛУУЛАХ" цогц системийг танилцуулж байна.



1. Замын гадаргуу
2. Эко ус нэвчүүлдэг чулуун хавтан
3. Ус дамжуулах нүх
4. Ус дамжуулах хоолой
5. Эко кварцан ус шүүгч цооног
6. Эко кварцан ус шүүгч плита

RECHSAND бохир усны цооногийн схем зураг

Борооны усыг авто замын өөрийн налуугаар дамжуулан (1) замын хажуугийн ус нэвтрүүлэх плита руу хуримтлуулан (2), эко ус нэвтрүүлэх плитагаар усны нүх руу оруулж (3), тэндээс ус дамжуулах хоолойгоор дамжуулан (4), эко кварцын ус шүүгч цооног руу оруулан (5) цааш дахин уг цооногоор дамжуулан борооны усыг аажмаар газрын гүнд шингээж, гүний усыг нөхөж өгдөг.

Онцлог:


- Эдийн засгийн хамгийн ашигтай хувилбараар зам дээрхи борооны усыг хуримтлуулан, газар доорхи

гүний усыг нөхнө.

- Борооны усыг үр дүнтэйгээр шингээснээр борооны усны хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэнэ.
- Бүтэц энгийн хялбар, гүйцэтгэл энгийн, уян хатан шинж чанар сайтай, хэрэглээний цар хүрээ өргөн зэрэг давуу талуудтай.

2. RECHSAND УСНЫ ХАМГААЛАЛТ, БАРИЛГЫН БОРООНЫ УСЫГ НӨӨЦЛӨХ ЗОРИУЛАЛТАЙ СИСТЕМ

Энэхүү систем нь барилгын давхаргын хавтан болон улны хавтанд зориулан эко борооны ус хуримтлуулах болон эргэлтэнд оруулан ашиглах системийг гарган ирэхэд чиглэгдсэн болно.



1. Эко ус нэвтрүүлэх чулуун хавтан
2. Наалдамхай тэгшилгээний үе
3. Хайрган үе
4. Эко агаар нэвтрүүлэх, ус нэвтрүүлдэггүй элсэн үе
5. Эко кварцан ус шүүгч нүх
6. Эко кварцан ус шүүгч элсэн үе
7. Эко кварцан ус шүүгч цооног
8. Борооны ус хуримтлуулах шугам хоолойн сүлжээ

Борооны усыг эко ус нэвтрүүлдэг чулуун материалаар дамжуулан наалдамхай тэгшилгээний үе, хайрган үед шингээсний дараа налуу бүхий эко хий нэвтрүүлдэг усны хамгаалалттай элсэн үед шингээж, эко кварцан ус шүүгч элсэн давхаргад хуримтлуулна.



Дараа нь борооны усыг эко кварцан ус шүүгч элсэн давхаргаар дамжуулан эко кварцан шүүгчтэй усны цооног руу оруулна.


Барилгын дээврийн хэсэг болон гаднах талбай дээр хуримтлагдсан борооны усыг борооны ус хуримтлуулах хоолойн сүлжээгээр дамжуулан эко кварцан ус шүүгч руу оруулж, тэндээс усыг урсгалын явцад нь эко кварцан ус шүүгч элсэн үе руу шингээнэ. Дараа нь эко кварцан ус шүүгч цооног руу оруулна.

Онцлог

- Зай талбай эзлэхгүй тул талбай ашиглалтын хувь хэмжээг дээшлүүлнэ
- Аюулгүй байдлын үзүүлэлт өндөртэй, олон төрлийн зориулалтыг цогцоор нь шийдсэн
- Усны нөөцийн эргэлт ашиглалтад сайн үр нөлөөтэй зэрэг давуу талуудтай

RECHSAND ДАЛД ХЭЛБЭРИЙН УС НӨӨЦЛҮҮР, ТАРИАЛАНГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ БОРООНЫ УСЫГ АГУУЛАХ СИСТЕМ

Үйлдвэрлэл инженерийн хэрэглээний ус дутмаг энэхүү хүнд үед эко борооны усны нөөц ашиглалтын системийг гарган ирэхэд чиглэгдсэн систем юм.



1. Агаар нэвтрүүлэх хамгаалалтын элсэн үе
2. Элс кварцын шүүгчтэй усны нүх
3. Ус цэвэршүүлэх элсэн үе
4. Элс кварцан ус шүүгч цооног
5. Борооны усны хоолой
6. Хөрсний суурь үе

RECHSAND далд хэлбэрийн нөөцлүүрийн схем зураг

Барилгын дээврийн борооны ус эсвэл гадаргуу дээр хуримтлагдсан борооны усыг борооны ус хуримтлуулах хоолойн сүлжээ руу оруулан эко кварцын ус шүүгч нүх руу оруулна. Усыг урсах явцын дунд нь эко цэвэршүүлэх элсэнд шингээх ба дараа нь эко ус цэвэршүүлэх элсэн давхаргаас эко кварцан ус шүүх цооног руу оруулна.

Усан сангийн суурийн болон дээд хэсгийн агаар нэвтрүүлдэг элс шорооны хамгаалалттай үе байх ба энэ үе нь усанд агуулагдах хүчилтөрөгчийн хэмжээг


хадгалан усны чанарт нөлөөлөхөөс сэргийлнэ.

Онцлог:

- Бүтэц болон гүйцэтгэл энгийн хялбар, том усан сан, усны нөөцлүүрийг өөрчлөн далд жижиг хэмжээний усан сан болгох боломжтой
- Ус шүүрэхээс урьдчилан сэргийлсэн мөн ууршилтын хамгаалалттай
- Газар тариалангийн зориулалттай усны эргэн ашиглалтыг сайжруулна

4.RECHSAND БУЛАГ, УНДНЫ УСЫГ ЦЭВЭРШҮҮЛЭН НӨӨЦЛӨХ ЗОРИУЛАЛТТАЙ СИСТЕМ

Хил хамгаалах пост болон хилээс хол зайтай уулын бүс "Шүүрэн шанаганы хэв маяг" карст геологийн бүсийн ундны усны хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн систем юм.



1. Усны хоолой
2. Ус шүүх уут
3. Усны цооногийн таг
4. Эко кварцан ус нэвтрүүлэх цооног
5. Эко цэвэршүүлэх ус шүүгч элс
6. Эко кварцан ус шүүгч цооног
7. Ус авах цооногийн таг
8. Гулсахаас сэргийлсэн тэгш тавцан
9. Нэвчилтийн хамгаалалттай хамгаалалтын үе
10. Нэвчилтийн хамгаалалттай усан сан
11. Цооногийн ёроолын суурь хавтан
12. Эко агаар нэвтрүүлдэг нэвчилтийн хамгаалалттай улны үе
13. Ус дамжуулах хоолой
14. Кварцан цооногийн таглааны хавтан
15. Бетонон суурь
16. Шороон суурь давхарга

Голын ус, борооны ус, хур тунадасны ус зэргийг хуримтлуулан ундны ус цэвэршүүлэн нөөцлөх зориулалттай системээр дамжуулан нөөцлөн хадгалах систем дэх усны хоолой, шүүгч уутаар эко кварцан ус нэвтрүүлэх цооног руу оруулж, дараа нь цэвэршүүлэх ус шүүх элсэнд шингээж, усыг цэвэршүүлээд кварцан ус шүүгч цооног руу оруулна. Тэндээс усны шахуурга эсвэл гараар усыг авч ашиглана.

Онцлог:

- Хуримтлуулах болон шүүж тунгаан цэвэршүүлэх адил алхамтай
- Нэвчилт болон ууршилтаас урьдчилан сэргийлсэн хамгаалалттай
- Нөөцлөлт болон чанарыг муутгахгүй хадгалах асуудлыг цогцоор шийдсэн

Мэдээллийг "МОНТС ХХК"-ийн захирал **Д.Мягмарсүрэн**

"ХАУСИНГ ХОЛД" ХХК-ИЙН МАШИНИСТ, ЗАСВАРЧИН ХҮДЭРТУЛГАТАЙ ХУВИЙН УРАН БҮТЭЭЛИЙН НЬ ТАЛААР ЯРИЛЦЛАА.



Танд энэ өдрийн мэнд хүргье

-Баярлалаа, танд болон нийтийн аж ахуйн салбарын бүх ажилчдад энэ өдрийн мэнд хүргье.

Нийтийн аж ахуйн салбарт хэдэн жил ажиллаж байгаа мөн энэ салбарт ажиллаж байгаадаа, өөрийн ажил мэргэжилдээ хир сэтгэл хангалуун байдаг вэ?

-Би нийтийн аж ахуйн салбарт 5 жил ажиллаж байна. Мэргэжилдээ дуртай, маш их сэтгэл хангалуун ажилладаг. Манай хамт олон сайхан нийтэч, найрсаг, хөдөлмөрч хүмүүс байдаг. Манай нийтийн аж ахуйн салбар ер нь их буянтай, өгөөжтэй сайхан салбар шүү дээ. Иргэд оршин суугчдын тав тухыг хангадаг.

Хэдэн настайгаасаа эхлэн зураг зурдаг болсон бэ?

-Багаасаа зураг зурдаг байсан. 13 настайдаа 10 жилд

байхдаа ангийнхаа хүүхдүүдийн зургийг зурах дуртай байж билээ.

Зурагт ихэвчлэн юун тухай өгүүлж байна?

-Өөрийн үндэс угсааны түүхийн сэдэв, өнөөгийн нийгмийн байдал, аж амьдрал, хөрөг зураг ихэвчлэн зурдаг.

Ямар нэртэй /сэдвийн/ уран бүтээл туурвиж байна?

-Миний зургийн цомгоос төрөлжүүлбэл амьдралын талаарх уран бүтээл байна.

Зураг зурснаараа өөртөө ямар сэтгэгдэл /мэдрэмж/ үлдээж чаддаг вэ?

-Зургаас тайвшрал, амар амгалан, аз жаргал мэдрэгддэг.

2013 онд төлөвлөж байгаа ажил байна уу?

-Байгаа маш их ажил төлөвлөж байна. Мэргэжлээ дээшлүүлж суралцана, хувийн уран бүтээлээ ч туурвина даа.

Баярлалаа. Таны ажилд амжилт хүсье.







МОНГОЛЧУУД УСЫГ ӨДӨР ТУТМЫН ХЭРЭГЦЭЭГЭЭ БОЛГОХ ХЭРЭГТЭЙ

- Өнөөдөр Улаанбаатарчууд болон орон нутгийнхны ундны ус эрүүл ахуйн шаардлага хэр хангасан байдаг юм бэ?

- Үүнийг тайлбарлахын тулд бид хэрэглэж буй усныхаа эх үүсвэрийн талаар ярих хэрэгтэй. Бидний хэрэглэж байгаа ус маш урт зам туулдгийг хүмүүс тэр бүр мэддэггүй. Гүнээс олборлосон усыг ариутгах гэж хлоржуулдаг. Усанд байдаг бичил биетүүд удаан хадгалалт, харанхуй, даралт багатай орчинд амархан үржих гээд байдаг учраас тэр. Дараа нь 40-50 жил болсон зэвтэй хуучин төмөр хоолойгоор урссаар танай гэрт хүрдэг. Нөгөө талаар крантны усанд дамжуулж буй шугам хоолойн зэврэлт, хаг хагшааснаас үүссэн төмрийн зэв, янз бүрийн давсны өнгөр гэх мэт механик хольцууд орсон байдаг. Цоргоны усыг тосоод харахад цэвэр тунгалаг юм шиг харагддаг ч шинжлээд үзэхэд механик хольц, ДВР буюу хлоржуулалтаас үүссэн дайвар бүтээгдэхүүний найрлагатай байдаг.



жишээ бол манай монголчууд цэвэр усыг байнга өдөр тутмынхаа хэрэглээ болгож чадаагүйгээс нүүр нь харлах, хуурайших, янз бүрийн батга, идээт үрэвсэл гарах гэх мэт. Жишээ нь үнэтэй гоо сайхны бүтээгдэхүүн хэрэглэж байсан ч зарим хүүхнүүд тийм сайхан харагддаггүйн гол учир нь нөгөө л цэвэр усыг уух, түүгээр арьс арчилгаандаа төдийлэн хэрэглэж заншаагүйтэй холбоотой. Манайд ирж байгаа хүмүүс гэдэс эвгүйцээд, нүүрээр юм гарлаа гээд ирдэг. Очоод хэрэглэж байгаа усыг нь шинжлэхэд зэв, хүнд метал, бүр хүний ялгадасны нян хүртэл илэрсэн тохиолдол бий. Ийм найрлагатай усаар үс, арьсаа арчилж байгаа тохиолдолд гоо сайханд хэрхэн нөлөөлөх нь ойлгомжтой. Цэвэршүүлсэн усаар арьсаа цэвэрлэхэд маш зөөлөн, торгомсог, толигор болдог бол үс гялалзсан эрүүл болдог. Сүүлийн үед хүмүүс гадна талаас нь арчлахаас илүүтэй дотор эрхтнээ тэр тусмаа ходоод, гэдсээ эрүүл байлгахыг чухалчилдаг болжээ. Энэ нь ч зөв. Өвчнөө намдаах гэж эмийг цэвэршүүлээгүй усаар даруулж уувал эм болох уу, хор болох уу гэдгийг бодолцох л хэрэгтэй.

- Бидний хэрэглэж байгаа ус ийм бохирдолтой байдаг бол эрүүл ахуйн шаардлага хангасан ус хэрэглэхийн тулд яах ёстой юм бэ?

- Цоргоноос усыг тосоод харахад цэвэр юм шиг харагддаг ч шинжлээд үзэхэд эрүүл ахуйн шаардлага хангадаггүй. Тиймээс эрүүл байхыг хүсвэл нярай хүүхдээс эхлээд бүх насны хүмүүс усыг цэвэршүүлж, хэрэглэх шаардлагатай. Хамгийн эхлээд хэрэглэж байгаа усаа мэргэжлийн байгууллагаар шинжлүүлэх хэрэгтэй. Манайд усныхаа дээжийг аваад ирвэл анхан шатны жинжилгээг үнэгүй хийгээд хими, физик, бактерлоги,

- Эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй ус хэрэглэснээр хүний биед үзүүлэх хор уршиг нь хэр юм бол ?

- Усыг ариутгахын тулд хлоржуулдаг. Тэгвэл тэр хлорын нэгдлүүд нь усан дах өвчин үүсгэгч нян, бактер, вирусыг устгадаг боловч усан дах бичил биетэн, гумины ба пульвохүчлүүдийн задралын бүтээгдэхүүн, хүний үйл ажиллагаанаас гаралтай бохирдуулагчид, байгалийн органик нэгдлүүдтэй усан дах идэвхтэй хлор нь урвалд орж, галогенжсэн нэгдлүүд үүсгэдэг байна. Энэ нэгдлүүд болох галогентметан, гаогент цууны хүчлүүд зэрэг 40-өөд нэгдлүүд нь хүний эрүүл мэндэд тааламжгүй нөлөө буюу хавдар үүсгэх эрсдэлтэй байдаг. Үүнээс гадна усан дах механик хольц, зэв хаг хагшаасыг шүүхгүйгээр усыг шууд хэрэглэснээр ходоод гэдэс, бөөр, шээсний замын архаг үрэвсэл, улмаар цөсний чулуужилт, бөөрний архаг дутагдалд оруулах зэргээр хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг. Хүний дотоод эрхтэнд нөлөөлөөд зогсохгүй гадаад өнгө үзэмжинд бас нөлөөлдөг. Үүний нэг тод





хүнд металлын найрлагыг хөндлөнгийн лаборторид шинжлүүлээд дараа нь ямар шүүлтүүр, яаж хэрэглэх талаар зөвлөгөөг үнэгүй өгдөг. Гол нь сайн чанарын, дэлхийд танигдсан, брэндийн ус цэвэршүүлэгчийг сонгох хэрэгтэй. Брэнд гэдэг нь маань өрсөлдөөний явцад чанар, технологи гээд бүх зүйлээрээ шалгарсан байдаг. Бидний 15 жилийн судалгаа, туршлагаас харахад Улаанбаатар хотын нөхцөлд дөрвөөс таван шатны шүүлтүүртэй цэвэршүүлэгчийг хэрэглэх шаардлагатай.

Эхний шүүлтүүр усны механик хольц болон хөвөгч зүйлс, зэв жижиг үлдэгдлийг, хояр дах нь хлорын үлдэгдэл болон органик бохирдлыг шүүнэ. Гурав дах шүүлтүүрээр нүдэнд үл харагдах механик бохирдлыг, дараа нь молекулын түвшинд хүнд металл, бактери, химийн бохирдлыг нь шүүгээд эцэст нь усанд ууссан хий, үнэр, амтыг арилгаж, байгалийн юм шиг амттай болгодог идэвхжүүлсэн нүүрсэн шүүлтүүрээр шүүдэг юм.

Дээрх таван шүүлтүүрээр шүүсэн усаа хэрэглэгч хэрвээ хүсвэл эрдэс минериалаар баяжуулж өгдөг нэмэлт төхөөрөмжийг суурилуулж өгдөг.



- Олон төрлийн төхөөрөмж байх юм. Эдгээрээс алийг нь ахуйн хэрэглээнд сонговол тохиромжтой вэ?

-Бид эрүүл мэнддээ анхаардаг хэн бүхний хэрэглээ болсон цэвэр усыг танд хүргэхээр "Эрүүл ус, эрүүл амьдрал" уриатайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Манай компани анх 1998 оноос эхлэн байгаль орчны үнэлгээ, зөвлөгөө, ус цэвэршүүлэх тоног

төхөөрөмжийн худалдаа чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд нийт хэрэглэгчиддээ хүрч ажиллахын тулд салбар дэлгүүрүүдээ нээн ажиллуулж, тэдний хэрэглээний онцлогт тааруулан АНУ-ын "Ecowater systems", Тайваны "Kemplo", Солонгосын "Coway", "Chungho", Италын "Atlas Filtri" брэндийн өрхийн болон оффисын зориулалттай, хот суурин газар, албан байгууллага, үйлдвэр үйлчилгээний зориулалттай ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжүүдийг санал болгож байна.

Эдгээрээс дэвшилтэт технологиор бий болгосон айл өрх албан тасалгаанд тавихад тохиромжтой өнгөлөг, содон дизайнтай 20-30 литрийнх, машиндаа аваад явчих аяны цэвэршүүлэгч, мөн орон сууцны барилгын халуун хүйтэн усны оролтон дээр тавигдах хог баригч, цэвэршүүлэх, зөөлрүүлэх иж бүрэн төхөөрөмж, өдөрт 2-200тн хүртэлх хэмжээний усыг цэвэршүүлэх хүчин чадалтай хүнсний болон эрчим хүч, уул уурхай, барилгын материалын үйлдвэрлэл, эмнэлэг сувилал, амралт, аялал жуулчлалын бааз зэрэг хаана чанартай ус шаардлагатай байна тэнд зориулсан олон төрлийн усны тоног төхөөрөмж, цэвэршүүлэгчийг сонгох хэрэгтэй.

- Танайх бохир ус цэвэрлэгээг хийдэг. Энэ талаараа мэдээлэл өгөөч?

- Манай компани технологийн шинэ дэвшилтэт санаа, төгс шийдэл, дэлхийд танигдсан олон зуун бүтээгдэхүүнээрээ хүрээлэн буй орчны эрүүл аюулгүй байх нөхцлийг хангаж, түүнд тулгамдсан ялангуяа төвлөрсөн бус тогтолцоотой айл өрх, эмнэлэг, сургууль, аж ахуйн нэгж байгууллагын ахуйн бохир ус, үйлдвэрийн технологийн хаягдалус, хур борооны усыг цэвэрлэх "Ногоон" технологи бүхий FAST-ийн байгууламж, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэдэг АНУ-ын BIO-MICROBICS корпорацийн албан ёсны гэрээт борлуулагч юм.

Сүүлийн 40 орчим жил хэдэн арван мянгаар олон улсын тавцанд үнэлэгдэж, биологи, биохими болон физикийн аргуудыг хослуулан бохир усыг цэвэрлэх технологийг ашиглаж байна. FAST-ийн эдгээр технологиуд нь, дэлхийн хаана ч тээвэрлэхэд тохиромжтой, овор бага, үзэмж сайтай дизайнтай, угсарч суурилуулахад хялбар, цэвэрлэх усны зардал нь олон янз, тогтмол өндөр бүтээмжтэй байдгаараа онцлогтой.

- Хэрэв иргэд болон аж ахуй нэгж байгууллагууд эдгээр ус цэвэршүүлэгчийг сонирхвол ямар хаягаар хандах вэ?

- Манай төв хуучнаар Лениний музейн ар талд орон сууцны 15-р байрны зүүн өргөтгөлд байрладаг. Манайх - Эрдэнэт хот, Уурхайчин баг, 3-р микро 20-р байр, 1 тоот

утас: 70355034, 99041101

- Дархан хот, Дархан их дэлгүүрийн нэг давхарт
Утас: 70370311

Хан уул дүүрэг "Kitchen all" худалдааны төв

13-р хороолол, Намянжугийн гудамж "Arina center"-т байрлаж салбаруудаараа үйлчилж байна.



"ЧАНДМАНЬ-БАЯНХОНГОР" ХУВЬЦААТ КОМПАНИ

ТҮҮХЭН ЗАМНАЛ



Манай байгууллага нь 1965 онд Үйлчлэх товчоо нэртэйгээр аймгийн төвийн хүн ам, албан газар, орон сууцны халаалт, ус хангамж, ариутгах татуурга, хог тээвэрлэлт, халуун ус, зочид буудал, тохижолт үйлчилгээгээр хангах зориулалттайгаар үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд 1978 онд Нийтийн Аж Ахуйн Үйлчилгээний яам байгуулагдсанаар тус салбар сумдын төвийн халаалт дизель станц, ус хангамж, хог тээврийн үйлчилгээг гүйцэтгэж, улмаар аймгийн төвийн ахуйн үйлчилгээтэй нэгдэн Нийтийн Аж Ахуйн Үйлчилгээний Удирдах Газар болон өргөжин тэлж үйл ажиллагаагаа явуулж байжээ. 1990 онд Нийтийн Аж Ахуйн контор болон зохион байгуулагдсан ба 1997 онд аймгийн өмч хувьчлалын комиссын шийдвэрээр тус газрын харьяа уурын зуухнуудыг хувьчилж, Нийтийн Аж Ахуйн Үйлчилгээний Хот Тохижилтын газар болон өөрчлөгдсөн бөгөөд 2001 оны 11-р сард аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 87 дугаар тогтоолоор "Чандмань-Баянхонгор" ХХК болон зохион байгуулагдан ажиллаж байгаад Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит бус хуралдааны 18/3 тоот тогтоолоор "Чандмань-Баянхонгор" Хувьцаат компани болон зохион байгуулагдаад байна.

Одоо тус компани нь Захиргаа аж ахуй, Цэвэр усан хангамж, ариутгах татуурга борлуулалт үйлчилгээ, Дулаан хангамж үйлчилгээ, Туслах үйлчилгээний хэсэг гэсэн нийт 4 хэсэгтэй 52 ажилтан ажилчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Манай байгууллага нь харилцагч байгууллага, хэрэглэгчдийн найдвартай түнш нь байж харилцагчдад үзүүлж буй үйлчилгээгээ стандартын түвшинд хүргэхийг эрхэмлэн тэдний итгэл хүлээсэн компани болох зорилт тавин ажиллахын зэрэгцээ үйл ажиллагаандаа шинэчлэлт, өөрчлөлт хийх, орчин үеийн техник технологи нэвтрүүлэх, ажилчдын ажиллах нөхцлийг сайжруулах, компанийн бизнесийн үйл ажиллагааг дээшлүүлэхэд, эдийн засгийн үр ашгийг нэвтрүүлэхэд анхааран ажиллаж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Үндсэн үйл ажиллагаа

- Баянхонгор аймгийн хүн ам, аж ахуйн нэгжийг цэвэр усаар хангах
- Саарал усыг татан зайлуулах
- Гэр хорооллын оршин суугчдыг зөөврийн усаар хангах
- 1-р багт орших зарим орон сууц, аж ахуйн нэгж албан байгууллагуудыг дулаанаар хангах
- Барилга угсралтын ажил гүйцэтгэх
- Аж ахуй нэгж, албан байгууллага, айл өрхийг тоолууруужуулах
- Байгаль орчны нөхөн сэргээлт

а. Усан хангамж - Ус хангамжийн эх үүсвэр нь гүний 2 худгаас хоногт 2000-2600 м3 ус олборлож жилд дунджаар 730.0-949,0 м3 орчим усыг 101 аж ахуйн нэгж албан байгууллага, 2394 айл өрхийг төвлөрсөн шугам сүлжээгээр, гэр хорооллын 6000 гаруй өрхийн 21,5 мянга орчим хүн амыг зөөврийн усан хангамжаар хангаж байна.

б. Ариутгах татуурга – Цэвэрлэх байгууламж нь 101 аж ахуйн нэгж албан байгууллага, 2394 айл өрхөөс ариутгах татуургаар хоногт 1400-1820 м3 саарал усыг татан зайлуулж байна.



Цэвэрлэх байгууламж

в. Дулаан хангамж: Баянхонгор сумын 29303.2 м3 эзлэхүүн бүхий 14 аж ахуйн нэгж, 8930 м2 талбай бүхий 238 айл өрхийг дулаанаар хангах үйлчилгээг явуулж



байна. Тус хэсэг нь бага чадлын бетон үйлдвэрлэл эрхэлж компанийнхаа аж ахуйн хэрэгцээнд зориулан ашиглаж байна.



Дулаацуулгын зуух

г. Туслах Үйлчилгээ: Аймгийн 3.4.5.6-р багийн оршин суугчдад 1 ээлжиндээ 6 хүнд үйлчлэх халуун ус, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор 300 тоннын багтаамжтай 2 ширхэг зоорийг 2011 ашиглалтанд онд оруулж үйлчилгээнийхээ хүрээг өргөтгөж байна.

д. Зөөврийн усан хангамж: Баянхонгор сумын гэр хороололын хүн амыг 2 автомашин, 34 ус түгээх байраар цэвэр усыг түгээж байна.



Манай компани нь жил бүр ажилчдынхаа дунд дараах ажлуудыг зохион байгуулдаг.

- Спортын таван төрлийн уралдаан тэмцээн
- Урлагийн гурван төрлийн уралдаан
- Ахмадуудаа жилд нэгээс хоёр удаа хүлээн авах
- Ажилчдын дунд болзолт уралдаан зарлаж, түрүүлсэн ажилчдыг хөрш орны ижил төрлийн байгууллагын туршлага судлуулж, сүүлийн үеийн техник технологитой танилцуулах
- Эх орны үзэсгэлэнт газраар аялуулах
- Компаний үйл ажиллагааг сурталчлах "Нээлттэй хаалганы өдөр"

Тус компани нь 2012 онд Хот байгуулалтын салбарын МОН-2301 төсөлд хамрагдан дараахь ажлууд хийгдэж байна. Үүнд:

Төслийн А хэсэг:

- Ундны усны эх үүсвэрийн худгийн 2 барилгыг засварлах, насос, тоног төхөөрөмжийг шинэчлэх, хлоржуулах барилга шинээр барих
- 2х1000 м3 багтаамжтай усан сан шинээр барих
- Гэр хороололд цэвэр усны 8.2 км шугам угсрах
- Гэр хороололд ус түгээх байр 5-г шинээр барих, одоо ашиглаж байгаа 9 ус түгээх байрыг засварлаж, цэвэр усны шугаманд холбох
- Хотын төвийн 4.4 км саарал усны гол шугамыг шинэчлэх
- 1,6 км цахилгаан дамжуулах агаарын шугам

татах, дэд өртөө угсрах
Цэвэрлэх байгууламжийг шинэчлэх



төслийн ажлын үйл явц




Шинээр барьсан худаг

Төслийн Д хэсэг "Байгууллагын хөгжил ба сургалт": Энэ хэсгийн хүрээнд "Компанийн сайн засаглал", "Байгууллагын стратеги төлөвлөлт, тэнцвэржүүлсэн үнэлгээний систем", "Ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр /АХЭХ/", "Төр хувийн хэвшлийн түншлэл, түүний гэрээ", "НББОУСтандарт нэвтрүүлэлт" зэрэг нийт таван удаагийн сургалтанд хамрагдаж, өөрийн аймагт 2 удаагийн сургалт зохион байгууллаа.



Баянхонгор аймаг "Чандмань-Баянхонгор" ХХКомпани Шаргалжуут рашаан сувилалд "Байгууллагын стратеги "Компанийн сайн засаглал" сэдэвт сургалт төлөвлөлт, тэнцвэржүүлсэн үнэлгээний систем" Сэдэвт сургалт

"ЧАНДМАНЬ-БАЯНХОНГОР" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЗАХИРГАА



БАРИЛГЫН САНТЕХНИКИЙН УГСРАЛТ ОСНАА-Н "ГАН -ТУС" ХХК

ТАНИЛЦУУЛГА

ЗАХИРАЛ Г.ТУНГАЛАГ

/ Техникийн ухааны магистр
мэргэшсэн инженер, НАА-н тэргүүний ажилтан/

1991 онд ЗХУ-ын Фрунзе хотын политехникийн дээд сургуулийг "Дулаан хангамж агаар сэлгэлт"-ийн инженерийн мэргэжлээр төгссөн . Орон сууцны системд 15 жил ажиллаж байгаа.

2009 онд Хувийн хэвшлийн орон сууцны Ган-Тус ХХК-ийг үүсгэн байгуулсан .

Барилгын сантехник угсралт , ОСНАА-н ГАН-ТУС ХХК



"Ган-Тус" ХХК-нь 2009 онд 8 хүний бүрэлдхүүнтэйгээр барилгын дотор сантехникийн угсралтын ажлыг хийж ажлынхаа гарааг эхэлсэн билээ .

Тус компани нь одоогийн байдлаар 24 хүний бүрэлдхүүнтэйгээр барилгын угсралтын болон орон сууц ашиглалтын гэсэн 2 хэсэгтэйгээр "НАА-н үйлчилгээ " "Барилгын дотор сантехникийн угсралтын ажил", "Усны тоолуур суурилуулах" тусгай зөвшөөрөлүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

2010-06-02-нд Монголын НАА-холбооны гишүүнээр элссэн .

Орон сууцны ашиглалтын хэсэг нь

Ерөнхий инженерээр ахлуулсан инженер техникийн ажилчид нь ХУД , СБД-н нутаг дэвсгэрт байрлах нийт-407 өрх , JS TOWER -оффисын барилгад 16 ялтсан бойлер , гадна ус дулааны 853 у/м шугамаар ус дулааныг түгээх , 294 у/м ариутгах татуургын шугам , 43 ариутгах татуургын худгаар бохир усыг татан зайлуулах , ус , дулаан , цахилгааны засвар үйлчилгээ , УДДТ/ ус дулаан дамжуулах төв/-ХЦТ-ийн горим тохиргоо , найдвартай үйл ажиллагааг 24 цагийн турш тасралтгүйгээр ханган үйл ажиллагаагаа явуулж байна.

Санхүүгийн хэсэг нь цалин , материалын ня-бо , орлогын ня-бо , байцаагч-2 гэсэн бүрэлдхүүнтэйгээр айл өрхийн тоолуурын заалт авах , нуугдмал хүн амыг илрүүлэх , орлогын төлөвлөгөөний биелэлтэнд хяналт

тавих зэрэг үйл ажиллагаа явуулж байна. Мөн айл өрхүүдийн усны тоолууранд хяналт тавьж ажилласнаар усны алдагдлыг 5% бууруулж чадсан . Айл өрхөд усны тоолуур ашиглалтын дэвтрийг нээж өгснөөр суугчид өөрсдийн усны хэрэглээн дээр хяналт тавихаас гадна , хэрэглэснийхээ хирээр төлбөрөө хийх бүрэн боломжтой болсон .

Урсгал засварын ажлаар:

2010-2012 оны хугацаанд урсгал засварын хүрээнд 41-р байрны ХЦТ-д балансын хаалт суурилуулах , ялтсан бойлеруудыг угаах , 57-р байрны хэрэгцээний халуун усны 70у/м шугамыг солих , 20.42-р байрны дулааны тоолуурын зайг сунгах , 57-р байрны гадна худгийн ф50мм-хаалт-2ш солих , 57.42-р байрны халуун усны циркуляцийн насос-3ш , 57-р байрны хүйтэн усны өргөлтийн насос-1 ш шинээр тавих зэрэг нийт 3.5.сая төгрөгийн урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэсэн байна .

Барилгын угсралтын хэсэг нь :

Барилгын сантехникийн угсралтын хэсэг нь инженер-1, засварчин-6 хүний бүрэлдхүүнтэйгээр өнгөрсөн хугацаанд 10 гаруй орон сууц , үйлчилгээний төв , хауснуудын дотор угсралтын ажлуудыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн улсын комиссд хүлээлгэн өгөөд байна.





2012 оны 3-р сарын 01-ээс 6-р сарын 01-ны хооронд усны тоолуур суурилуулах тусгай зөвшөөрлийн хүрээнд Жигс-Ундарга компанитай гэрээ хийж ажилласнаар ОСНААУГ-ын харьяа Ашид –Ундрах ХХК-ны айл өрхүүдэд усны тоолуур суурилуулах ажлыг зохион байгуулан нийт 450 гаруй өрхөд 2237 ш тоолуурыг суурилуулан төлбөрийн хэрэгслэл болгосон байна.

бөмбөгийн анхдугаар тэмцээнд Нинжин ахлагчтай эмэгтэйчүүдийн баг 1-р байр эзэлж алтан медалийн эзэд боллоо.



Говь сүмбэр аймаг дахь Төвийн бүсийн мэргэжлийн ур чадварын тэмцээнд Л.Батболд ахлагчтай баг амжилттай сайн оролцлоо.

Манай хамт олны ажлыг өндрөөр үнэлж барилгын салбарын "Стандарт- 2012", нийгмийн даатгалын "Тэргүүн-Оюу" цомын эзнээр тус тус шагнасан нь бидний хийж бүтээх эрмэлзэлд урам өгсөн үйл явдал болсон юм.



"Тэргүүн-Оюу" цом , батламж

Манай хамт олон нь дээд газруудаас зохиогдож байгаа урлаг , спорт , мэргэжлийн уралдаан тэмцээнд хамт олноороо идэвхитэй оролцдог . 2009 онд Ар-Жанар ХХК-дээр зохиогдсон хувийн хэвшлийн орон сууцны конторнуудын дунд зохиогдсон уралдаанд Богд-Асар ХХК-тай хамт нэг баг болон, 2011 онд Говь-сүмбэр аймагт зохиогдсон Улсын хэмжээний мэргэжлийн сонгон шалгаруулах тэмцээнд багаараа тус тус амжилттай сайн оролцлоо . Мөн Хувийн Хэвшлийн Орон Сууцны Компаниудын дунд зохиогдсон сагсан

Манай хаяг:

СБД-ийн 3-р хороо Нарны зам 41-р байр 12 тоот

Холбоо барих утас :

Оффис-№70131522 ,

Диспетчер - 91621944,96691943 ,96681942

Инженерүүд- 96009552 , 99949593

E-Mail: www.gantus67@yahoo com.



ЖИГС-УНДАРГА ХХК

ЛОВЧ ТАНИЛЦУУЛГА

ЖИГС-Ундарга ХХК нь :

- Хэмжих хэрэгслэлийн худалдаа, засвар үйлчилгээ, суурилуулалт
- Цэвэрлэх байгууламж барих
- Усны, цахилгааны болон холбооны тусгай зориулалтын тоног төхөөрөмжүүдийн худалдаа, суурилуулалт зэрэг гурван үндсэн төрлийн ажил эрхлэн явуулж байна.

Цэвэрлэх байгууламж

Тус ЖИГС-Ундарга ХХК нь Германы Бергман компанитай хамтран германы технологиор цэвэрлэх байгууламж барих ажил хийж байна.

ДН брэндийн эргэлддэг сэнсэн хүрдтэй, хуурай цагийн механизмтай, урьдчилсан Цэвэрлэх байгууламж


- Анхдагч цэвэршүүлэлт ба тунгаалт
- Биофильмийн реактор
- Дахин цэвэршүүлэлт



- Цэвэрлэх байгууламжийн өндөр ачаалал
- Ажиллагааны хямд зардал
- Лагийн хэмжээ бага
- Суурилуулахад хялбар
- Шалгарсан WSB®-технологи

Төгс шийдэл

Байгууламж нь анхдагч цэвэршүүлэлт, тунгаагуур, биореактор зэргээс бүрдэнэ. Анхны худагт бохирын анхдагч цэвэршүүлэлт явагдах ба дараа нь тусгай худагт хадгалагдан биологийн цэвэрлэх процесс хийгдэнэ. Мөн энэ үед илүүдэл лагийг цэвэрлэх



биологийн процесс явагддаг.


Биореакторт бохирын усыг агааржуулж улмаар биомедиатай урвалд орно. Агааржуулалтын дараа тайван орчинд тунгаах процесс явагдаж лаг болон хатуу биетүүд тунадаг. Гадагшлуулах хоолойгоор цэвэрлэгдсэн ус урсан гарна. Түүнчлэн тайван орчинд тунгаах процесс болсны дараа азотын хүчлийн давсны задрал явагдана.



- Найдвартай ажиллагаа
- Улирлын хэрэглэгээнд тохируулах боломжтой
- Өөх, тос гэх мэт тослог ихтэй бодисын цэвэрлэгээ
- Ажиллагааны болон ашиглалтын хямд зардал

Ариун цэврийн шаардлага хангасан Хоолны газар

WSB® clean gastro нь хоолны газрын ариун цэврийн шаардлагыг хангах зориулалттай. Хоолны газруудад хэрэглэгчдийн тоо улирлын чанартай байдаг. Зуны дэлгэр дулаан цагт хэрэглэгчдийн тоо ихсэж өвөл хүйтний улиралд хэрэглэгчдийн тоо багасдаг. Үүнтэй холбоотойгоор бохирын хэмжээ их бага байдаг. Энэхүү системд тохируулалт хийх боломжтой бөгөөд цэвэршүүлэх ажиллагааг чанарын өндөр түвшинд гүйцэтгэдэг. Мөн системд тос, өөх бүхий тослогтой бохирыг стандартын дагуу цэвэршүүлэх боломжтой.



WSB Clean Pro

- WSB® ба SBR-ийн нэгдмэл ажиллагаа
- Нүүрстөрөгч болон нитратийг задалдаг
- Дахин цэвэршүүлэлт шаардлагагүй
- Ажиллагааны болон ашиглалтын бага зардал
- Нийтийн бохирын хэмжээнээс үл хамаарал



Цэвэрлэх процесс нь үр дүнтэй.

WSB® clean pro байгууламжийн бүтэц, загвар дээр Та сонголтоо хийх боломжтой. Манай дэвшилтэт технологи уян хатан чанартай тул Таны төслийн шаардлагад нийцүүлж болно.


Технологийн процессын давуу талууд:

- Нитратжуулах температур нь 12 °C хэмээс доош
- Нитратжуулах болон азотын хүчлийн давсны задралын явц багадаа 30-аас 50%
- Цэвэршүүлэлтийн шатуудад лагийн хэмжээ бага
- Патоген буюу өвчин үүсгэгч нянгуудыг микробиологийн аргаар устгана
- Микро организмууд нь хорт материалуудад дасан зохицсон
- Барилга байгууламжийн байдлаас хамаарахгүй үйл ажиллагаатай
- Хүчилтөрөгчийн ашиглалтыг нэмэгдүүлсэн

Хаягдалгүй



WSB® процессын чанартай, тогтмол цэвэрлэх ажиллагааны үр дүнд зардал бага, газрын гадаргууд хаягдалгүй байдаг. 4-10 хэрэглэгчийн цэвэрлэх байгууламж нь зөвхөн нэг худагтай байдаг. Байгууламжийн бүтцийн хэмжээсийг хүснэгтээр харуулав.



- (1)ОХ - Гадаргуу дахь худагны тагны дээд хязгаараас Оролтын хоолойн доод ирмэг хүртлэх хэмжээс
(2)ГХ - Гадаргуу дахь худагны тагны дээд хязгаараас Гаралтын хоолойн доод ирмэг хүртлэх хэмжээс

Усны алдагдал илрүүлэх багаж

Усны найдвартай хангамж нь олон талын ач холбогдолтой. Цэвэр ус нь эдийн засгийн үнэт хэрэглэгээ төдийгүй дэлхий дээрх хамгийн чухал хоол хүнс юм. Нөөц ундарга нь хомсдож буй хэдий ч усны хэрэгцээ, хэрэглээ улам бүр өсөн нэмэгдсээр байна. Энэ нь зөв зохистой ус хангамж, хуваарилалтыг зүй ёсоор шаарддаг.

Усны хоолойноос ус алдагдагснаар санхүүгийн алдагдалд хүрэхээс гадна ундны усны цэвэршилт, чанарт багагүй хор хөнөөл учруулдаг. sebaKMT бүтээгдэхүүнүүд нь усны алдагдлыг илрүүлдэг.

Усны алдагдал илрүүлэлтийн ажиллагаа нь 3 түвшинд явагддаг. Үүнд:

1. Хэсэгчилсэн хэмжилт: Шугам сүлжээний тодорхой хэсгийн байдал, мэдээллийг тодорхойлодог.
2. Урьдчилсан байдлаар алдагдал, гэмтлийн байршил тогтоох
3. Нарийвчилсан алдагдал, гэмтлийн байршил тогтоох,

Усны даралт ба урсгалын хэмжилт
Дууны түвшин ба давтамжийн бууралт
Харьцуулалт
Газрын микрофон ба хийн илрүүлэлтийн төхөөрөмж
Хэрэгслүүд



Орчин үед, цахилгаан эрчим хүч, энерги үйлдвэрлэх, ханган нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх салбарт кабелийн болон шугамын засвар үйлчилгээ, гэмтэл, эвдрэлийн байршил тодорхойлох зэрэг нь хэрэглэгчдийг найдвартай, чанартай эх үүсвэрээр хангах асуудлын гол үндсэн хэсэг болж байна.

Гэмтэл эвдрэл гарсан тохиолдолд зардал мөнгө болон цаг хугацаа ихээхэн шаарддаг. Нэг талаар хэрэглэгч хурдан хугацаанд холбогдох, санхүүгийн болон эдийн засгийн, эд материалын хор хохиролыг багасгах, нөгөө талаар өндөр зардалтай ажлыг аль болох үр дүнтэй, бүтээмжтэй хийх шаардлагатай байдаг. Маш найдвартай, энгийн ажиллагаатай, зөв технологи - SebaKMT - нь кабель ба шугамын эвдрэл, гэмтэл, доголдлыг хурдан, найдвартай, үр ашигтай олж илрүүлнэ.



Вэб: www.jigs.mn
Утас: 99117086



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН "ДАРХАН-УС СУВАГ" ХК-ИЙН 2012 ОНЫ "ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА"-УУД



Хөдөлмөрийн аварга
Г.Батболд
Инженер техникийн ажилтан

Инженер техникийн ажилтнуудын 2012 оны "Хөдөлмөрийн аварга" тооцооны нягтлан бодогч Ганболд овогтой Батболд.

Төрсөн он сар өдөр: 1981.03.02.

Мэргэжил: нягтлан бодогч.

Тус байгууллагад ажилд орсон: 2009.04.01.

2012 онд хийсэн ажил: Дархан хотын 1200 гаруй аж ахуйн нэгж, 10385 айл өрхийн цэвэр, бохир усны тооцоо хийж ажилласанаар усны өр авлагыг 12,2%-аар бууруулсан.

2009 оноос санхүүгийн diamond программ, усны waterwill программуудыг нэвтрүүлж ажилласан.



Хөдөлмөрийн аварга
П.Цогтбаяр
Усан хангамжийн албаны засварчин

Усан хангамжийн албаны 2012 оны "Хөдөлмөрийн аварга" шугам хоолойн засварчин Пүрэвдорж овогтой Цогтбаяр.

Төрсөн он сар өдөр: 1976.12.14.

Мэргэжил: Ус сувгийн засварчин.

Тус байгууллагад ажилд орсон: 1997.03.01.

2012 онд хийсэн ажил: Цэвэр усны шугам хоолойн үзлэг эргүүлийг гарфикийн дагуу хийж, шугам сүлжээнд 201 удаа аваарь гэмтэл гарсныг нормативт хугацаанд нь засварлан хэвийн ажиллагаанд оруулсан. Мөн d50мм-ийн хуванцар хоолойг 156м газарт хаалт арматурын хамт, d200мм-ийн хуучин шугамыг 388м газарт d100мм-ийн хуванцар шугамаар шинэчлэн солиход хамт олноо хошуучлан ажилласан. D15-32мм-ийн винтель 16ш, d50-250мм-ийн хаалт 16ш-ийг шинээр сольсон.



Хөдөлмөрийн аварга
Д.Уранчимэг
Ариутгах татуургын албаны машинист

Ариутгах татуургын албаны 2012 оны "Хөдөлмөрийн аварга" машинист Дүгэрээ овогтой Уранчимэг.

Төрсөн он сар өдөр: 1966.06.28.

Мэргэжил: Ус сувгийн машинист.

Тус байгууллагад ажилд орсон: 1984.07.01.

2012 онд хийсэн ажил: Дархан хотын үйлдвэр, аж ахуйн нэгж, орон сууцанд оршин суугч айл өрхүүдийн бохир усыг татан зайлуулж, биологийн аргаар цэвэрлэх төв цэвэрлэх байгууламжийн ээлжийн ахлах машинистаар ажиллаж насос тоног төхөөрөмжийн урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг тогтмол хийж ажилласнаар ямар нэгэн аваарь гэмтэлгүй ажилласан. Ариутгах татуургын алба нь 2012 онд 2980,86м³/мЗ бохир ус татан авч цэвэрлэн, 1513,88м³/мЗ бохир усны борлуулалт хийсэн. Бохир усны цэвэршилтийн түвшин 90,1% байна.



Хөдөлмөрийн аварга
Ш.Байгалмаа
Техник үйлчилгээний албаны
диспетчер, инженер

Техник үйлчилгээний албаны 2012 оны “Хөдөлмөрийн аварга” диспетчер инженер Ширнэн овогтой Байгалмаа.

Төрсөн он сар өдөр: 1966.11.18.

Мэргэжил: Сантехникийн инженер.

Тус байгууллагад ажилд орсон: 1993.11.01.

2012 онд хийсэн ажил: Орон сууцанд оршин суугч айл өрхийн 1597 дуудлага, цэвэр усны шугам хоолойн 201 удаагийн гэмтэл, бохир усны шугам хоолойн 130 удаагийн бөглөрөлт гэмтлийг барагдуулахад диспетчерийн удирдлагаар хангаж ажиллалаа. Ээлжийн хугацаанд нийт станц объектуудын ажилд хяналт тавьж, цэвэр усны олзворлолт шахалт, үйл ажиллагааг teamviewer программыг ашиглан хянаж ажиллав.



Хөдөлмөрийн аварга
Б.Ганбат
Орон сууцны албаны нарийн
хэмжүүрийн засварчин

Орон сууцны албаны 2012 оны “Хөдөлмөрийн аварга” нарийн хэмжүүрийн засварчин Байгалмаа овогтой Ганбат.

Төрсөн он сар өдөр: 1986.01.20.

Мэргэжил: Сантехникийн засварчин.

Тус байгууллагад ажилд орсон: 2009.01.26.

2012 онд хийсэн ажил: Дархан хотын аж ахуйн нэгж, албан байгууллагуудын 98%, орон сууцанд оршин суугч айл өрхийн 85%-ийг хэрэглээний цэвэр усны тоолуураар тоолууржуулах ажилд биечлэн ажиллаж ирлээ. Үүнд: 2009 онд 910ш, 2012 онд 580ш, 2011 онд 630ш, 2012 онд 760 ш тоолуурыг тус тус суурилуулсан ба айл өрхийн цэвэр усны тоолуурт гарсан гэмтлийг цаг алдалгүй богино хугацаанд чанартай засварласнаар усны алдагдлыг бууруулах, хэрэглэгчдийн бодит хэрэглээг тогтоох, усны нөөцийг нэмэгдүүлэх, усыг зөв зохистой, хэмнэлттэй хэрэглүүлэх бололцоо нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.



Хөдөлмөрийн аварга
С.Энхтуяа
Хэрэглэгчийн албаны ус олгогч

Хэрэглэгчийн албаны 2012 оны “Хөдөлмөрийн авагра” ус олгогч Сумьяасүрэн овогтой Энхтуяа.

Төрсөн он сар өдөр: 1972.01.02.

Мэргэжил: Худалдагч.

Тус байгууллагад ажилд орсон: 2004.09.07.

2012 онд хийсэн ажил: С.Энхтуяа нь 2004 оноос ус түгээх байрны ус олгогчоор ажиллаж байгаа ба Монгол улсын Засгийн газрын "НААҮ-ийн салбарыг хувьчлах хөтөлбөр", засгийн газрын 182 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тус компани 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс ус түгээх байруудыг түрээсийн гэрээнд оруулсаны дагуу 7.8 дугаар ус түгээх байрны түрээслэгчээр ажиллаж байна. 2012 онд 1300.5м3 ус борлуулсан.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/
/"Төрийн мэдээлэл", 2012 он, №22/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомж

2.1.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар байгалийн ургамал, ус, ой, ан амьтны нөөцийг ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Газар болон түүний хэвлийн нөөц ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Төлбөр төлөгч, түүнийг бүртгэх

4.1.Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгч нь Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд байна.

4.2.Байгалийн нөөц ашиглах зөвшөөрөл олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

4.3.Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ.

4.4.Энэ хуулийн 4.3-т заасан мэдээлэлд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, байршил, ашиглах хугацаа, хэмжээ, тоног төхөөрөмжийн хүчин чадал зэрэг шаардлагатай үзүүлэлтийг тусгана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨЛБӨР НОГДОХ ЗҮЙЛ, ҮНЭЛГЭЭГ ТОГТООХ

5 дугаар зүйл.Ургамал ашигласны төлбөр ногдох зүйл

5.1.Дараах ангиллын ургамалд төлбөр ногдуулна:

5.1.1.нэн ховор ургамал;

5.1.2.ховор ургамал;

5.1.3.элбэг ургамал.

6 дугаар зүйл.Ус, рашааны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл

6.1.Дор дурдсан зориулалтаар ашигласан ус, рашаан тэдгээрийн орчинд төлбөр ногдуулна:

6.1.1.хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус;

6.1.2.уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан ус;

6.1.3.эмчилгээ, сувилгаа, халаалт болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан рашаан;

6.1.4.эрчим хүч үйлдвэрлэх, тээвэр хийх болон усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашааны орчин.

7 дугаар зүйл.Ойн нөөц ашигласны төлбөр ногдох зүйл

7.1.Аливаа зориулалтаар ойгоос бэлтгэж ашигласан бүх төрлийн хэрэглээний мод, түлээнд төлбөр ногдуулна.

7.2.Ойн дагалт баялгийн нөөц самар, мөөг, давирхай, шилмүүс, мөчир, үр, хусны шүүсэнд төлбөр ногдуулна.

8 дугаар зүйл.Ан амьтны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл

8.1.Төлбөр ногдох зүйл нь дор дурдсан зориулалтаар ашигласан ан амьтан байна:

8.1.1.ахуйн зориулалтаар агнасан, барьсан;

8.1.2.үйлдвэрлэлийн зориулалтаар агнасан, барьсан;

8.1.3.тусгай зориулалтаар агнасан, барьсан /соёл, шинжлэх ухаан, тусгай төлбөртэй/.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨЛБӨР ТООЦОХ ҮЗҮҮЛЭЛТ, ТЭДГЭЭРИЙГ ТОДОРХОЙЛОХ

9 дүгээр зүйл.Байгалийн ургамлын нөөц ашигласны тооцох үзүүлэлт

9.1.Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлтийг ургамлын тухайн үеийн жинг килограммаар



илэрхийлсэн нэгж дэх тухайн зүйл ургамлын тоо, хэмжээг тооцоолсон экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар тооцно.

10 дугаар зүйл. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт

10.1. Усны нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлно:

10.1.1. усан цахилгаан станц, усан замын тээвэр, усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх, аялал зугаалга, биеийн тамир зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус, усан орчин ашигласан тохиолдолд тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын дүнгээс;

10.1.2. хүн амын унд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ашигласан усыг шоо метрээр;

10.1.3. уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усыг шоо метрээр.

10.2. Рашаан ашигласны төлбөр тооцох үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлно:

10.2.1. эмчилгээ, сувилгааны зориулалтаар рашаан ашигласны төлбөрийг эмчлэн сувилуулсан хүн-хоногийн тоогоор;

10.2.2. үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар рашаан ашигласны төлбөрийг шоо метрээр.

11 дүгээр зүйл. Ойн нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт

11.1. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг дор дурдсан үзүүлэлтээр тооцно:

11.1.1. ургаа мод огтолж, түүний үндсэн хэсгээс бэлтгэсэн хэрэглээний мод, түлээг нягт шоо метрээр, үзүүр, мөчрийг сийрэг шоо метрээр;

11.1.2. ойгоос хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүүг цэвэрлэж түлээ бэлтгэхэд сийрэг шоо метрээр.

11.2. Ойн дагалт баялгийн нөөцийг бэлтгэхэд хусны шүүсийг литрээр, бусад ойн дагалт баялгийн нөөцийг килограммаар тооцно.

12 дугаар зүйл. Ан амьтны нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт

12.1. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийг дараах үзүүлэлтээр тооцно:

12.1.1. үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөрийг килограммаар;

12.1.2. ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих иргэнээс төлбөрийг агнасан, барьсан шувуу, загасны ширхгээр;

12.1.3. ахуйн зориулалтаар агнах бусад ан амьтны төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээгээр;

12.1.4. ан амьтныг амьдаар нь барьж эзэмшин, гаршуулан үржүүлж, эмийн болон бусад түүхий эд бэлтгэж ашигласны төлбөрийг борлуулалтын орлогоор;

12.1.5. ан амьтныг амьдаар нь төрөөс худалдан авч өмчилсний төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээгээр;

12.1.6. гадаадын иргэнд агнуулсан болон гадаад улсад амьдаар нь аливаа зориулалтаар гаргасан ан амьтны төлбөрийг тухайн ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнээр.

13 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн

орлогын хэсэг, түүний төрөл

13.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэгт / цаашид "төлбөрийн орлогын хэсэг" гэх/ төсвийн жилд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хуваарилсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө багтана.

13.2. Төлбөрийн орлогын хэсгийг дор дурдсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдүүлнэ:

13.2.1. байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого;

13.2.2. ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого;

13.2.3. ойн нөөц ашигласны төлбөрийн орлого;

13.2.4. ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого;

13.2.5. газрын нөөцийн төлбөрийн орлого.

13.3. Ашигт малтмалын нөөц ашигласны болон байгаль орчныг бохирдуулсны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн хувь, хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

13.4. Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

13.5. Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг Засгийн газар батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨЛБӨРИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ

14 дүгээр зүйл. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

14.1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан төлбөр тооцох үзүүлэлт дэх экологи-эдийн засгийн үнэлгээний дор дурдсан хувиар тооцон төгрөгөөр тогтооно:

Төлбөр ногдох байгалийн ургамал	Төлбөр тооцох үзүүлэлт дэх экологи-эдийн засгийн үнэлгээний хувь	
	Доод	Дээд
1. Нэн ховор	25	30
2. Ховор	15	20
3. Элбэг	5	10

14.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 14.1-д заасан төлбөрийн хэмжээний хязгаарт багтаан ургамлын нөөц, тархац, ач холбогдол, ашиглагдах эрхтний онцлог, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан ургамлын нэр төрөл тус бүрээр төлбөрийн хэмжээг тогтооно.

15 дугаар зүйл. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

15.1. Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг энэ хуулийн 10.1-д заасан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:



Төлбөр ногдох ус	Төлбөрийн хязгаар / экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар/			
	Гадаргын усанд		Газрын доорх усанд	
	доод	дээд	доод	дээд
1.Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	1	10	5	20
2.Хүнд үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	10	40	20	50
3.Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	10	30	20	60
4.Авто зам, засварт ашигласан усны шоометр тутамд	10	30	20	70
5.Хөнгөн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	10	30	10	40
6.Хүнсний үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд:				
а/ Архи, пиво, соггууруулах ундаа	10	40	20	40
б/ Ундаа, цэвэр ус	10	30	10	20
в/ Талх, чихэр, нарийн боов, бусад	1	10	1	20
7. Уул уурхайн үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд:				
а/ ашигт малтмал олборлох, баяжуулах	10	40	20	60
б/эсийн баяжмал, хайлуур жонш баяжуулах	10	50	20	70
в/ усыг шавхан зайлуулах	10	15	15	50
г/ эрэл, хайгуулын өрөмдлөг хийх	10	30	20	50
8.Эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	10	15	15	30
9.Газар тариалангийн үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд	1	20	10	40
10.Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласан усны шоометр тутамд	10	30	15	50
Төлбөр ногдох ус	Үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын дүнгээс тооцох төлбөрийн хязгаар /хувиар/			
	Гадаргын усанд			
	доод	дээд		
11.Усан цахилгаан станц, усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх	1		30	
12. Усны түгээмэл тархацтай амьтан, ургамал үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, аялал зугаалга, усан спортын байгууламж	1		20	

15.2.Рашаан ашигласны төлбөрийн хэмжээг энэ хуулийн 10.2-т заасан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

Төлбөр ногдох рашаан	Хэмжих нэгж	Төлбөрийн хязгаар /төгрөгөөр/			
		Халуун		Хүйтэн	
		доод	Дээд	доод	дээд
1.Эмчилгээ, сувилгааны зориулалтаар ашиглахад	Хүн-хоног	100	500	50	400
2.Үйлдвэрлэлийн болон үйлчилгээний зориулалтаар ашиглахад	Шоо-метр	500	1500	1000	3000

15.3.Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг энэ хуулийн 15.1-д заасан хязгаарт багтаан Засгийн газар, рашаан ашигласны төлбөрийн хэмжээг энэ хуулийн 15.2-т заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус тогтооно.

15.4.Халуун рашааныг үндсэн ашиглалтад нь нөлөө үзүүлэхгүйгээр халаалтын зориулалтаар ашиглавал ногдуулах төлбөрийн хэмжээг тухайн орон нутгийн халаалтын хөлсний 50 хувиар тогтооно.

15.5.Байгалийн халуун усыг халаалтын зориулалтаар ашиглавал ногдуулах төлбөрийн хэмжээг тухайн орон нутгийн халаалтын хөлсний 50 хүртэл хувиар, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ашиглавал ус ашигласны төлбөрийн 50 хүртэл хувиар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож болно.

15.6.Энэ хуулийн 15.3, 15.5-д заасан төлбөрийн хувь, хэмжээг ус, рашааны нөөц, чанар, ашиглалтын хэлбэр, зориулалтыг харгалзан тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, онцлогтой уялдуулан ялгавартай тогтооно.

16 дугаар зүйл. Ойн нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

16.1.Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээнээс энэ хуулийн 11.1.1-д заасан хэрэглээний

модонд 6.0-30.0 хувь, энэ хуулийн 11.1.2-т заасан түлээнд 2.0-10.0 хувиар тооцно.

16.2.Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээ, бэлтгэж тээвэрлэх зай, модны төрлийг харгалзан энэ хуулийн 16.1-д заасан хязгаарт багтаан Засгийн газар ойн мужлал бүрээр ялгавартай тогтооно.

16.3.Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигладаг аж ахуйн нэгж, байгууллагын мод тээврийн зайг мод бэлтгэлийн талбайгаас доод агуулах хүртэл, агуулахгүй бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрсөн цэг хүртэл, төвлөрсөн цэггүй бол уг мод бэлтгэсэн талбайд хамгийн ойр орших сумын буюу аймгийн төв хүртэлх зайгаар тус тус тооцно.

16.4.Аж ахуйн нэгж, байгууллага хуш модыг тусгай зөвшөөрлөөр бэлтгэх тохиолдолд түүнд тухайн ойн бүс нутагт шинэс мод бэлтгэж ашиглахад ногдуулдаг төлбөрийг 3 дахин өсгөсөнтэй тэнцүү хэмжээний төлбөр ноогдуулна.

16.5.Ойн дагалт баялгийн нөөцийг ашигласны төлбөрийн хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

17 дугаар зүйл. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

17.1.Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн доод, дээд хязгаарыг дараах байдлаар тогтооно:

17.1.1.үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөрийг килограмм тутамд 700-1000 төгрөгөөр;

17.1.2.ахуйн, үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнасан бусад ан амьтны төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар;

17.1.3.ан амьтныг амьдаар барьж эзэмшин, гаршуулан үржүүлж эмийн болон бусад түүхий эд бэлтгэж ашигласны төлбөрийг уг түүхий эдийн борлуулалтын орлогын 10-20 хувиар;

17.1.4.ан амьтныг амьдаар нь төрөөс худалдан авч өмчилсний төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи эдийн засгийн үнэлгээний 90-100 хувиар;

17.1.5.гадаадын иргэнд агнуулсан ан амьтны нөөцийн төлбөрийг тухайн ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнийн 80-90 хувиар;

17.1.6.амьдаар нь гадаад оронд гаргасан ан амьтны төлбөрийг гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнийн 80-90 хувиар.

18 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн хувь, хэмжээ

18.1.Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

18.2.Энэ хуулийн 18.1-д заасан орлогын хувь, хэмжээнээс дээш байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухайн жилийн үндсэн чиглэлд газар, ус, рашаан, ой, ургамал, амьтны нөөцийг хамгаалах нөхөн сэргээх талаар тусгагдсан



Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/
1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	30 хувь
2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50 хувь
3. Газрын нөөцийн төлбөрийн орлого	30 хувь
4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь
5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	55 хувь

зорилт, арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулан улсын төсвөөс нэгдсэн журмаар зарцуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨЛБӨРӨӨС ЧӨЛӨӨЛӨХ, ХӨНГӨЛӨХ

19 дүгээр зүйл. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

19.1. Дараах зориулалт, хэрэгцээгээр байгалийн ургамлын нөөц ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө:

19.1.1. элбэг ургамлыг ахуйн хэрэгцээнд ашигласан иргэн;

19.1.2. ховор болон элбэг ургамлыг судалгаа шинжилгээний зориулалтаар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;

19.1.3. байгалийн ургамлыг хадлан бэлчээрийн зориулалтаар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага.

19.2. Элбэг ургамал ашигласны төлбөрийг хөнгөлж болох бөгөөд төлбөрийг хөнгөлөх нөхцөл, болзол, хувь, хэмжээг тухайн орон нутгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

20 дугаар зүйл. Усны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

20.1. Дараах зориулалтаар ус ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө:

20.1.1. хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах;

20.1.2. түймэр унтраах болон байгалийн бусад гамшигтай тэмцэх;

20.1.3. усыг үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд эргүүлэн ашигласан.

20.2. Дараах зориулалтаар ус ашигласан төлбөр төлөгчийн төлбөрийг Засгийн газраас тогтоосон хувь, хэмжээгээр хөнгөлж болно:

20.2.1. унд, ахуйн зориулалтаар усны эрдэсжилт, хатуулгыг нь цэнгэгжүүлж зөөлрүүлэн ашигласан;

20.2.2. ан амьтан хамгаалах, өсгөн үржүүлэх, нутагшуулах болон ургамал тарьж ургуулах замаар байгалийн баялгийг нөхөн сэргээх;

20.2.3. хаягдал ус цэвэрлэж, эргүүлэн ашигласан тохиолдолд тухайн хэмжээгээр;

20.2.4. цас, бороо, үерийн усыг хуримтлуулж мал аж ахуй, газар тариалангийн зориулалтаар ашигласан.

21 дүгээр зүйл. Ойн нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

21.1. Хилийн бүсийн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч өөрийн албан ажлын байр барих зориулалтаар ойгоос хэрэглээний мод бэлтгэж ашигласан бол төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө.

21.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойд арчилгаа хийх, хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүү бэлтгэх зэрэг ойн цэвэрлэгээний аргаар хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашиглавал төлбөрийг хөнгөлж болох бөгөөд хөнгөлөлтийн хувь, хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

22 дугаар зүйл. Ан амьтны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

22.1. Төлбөрөөс дараах тохиолдолд чөлөөлнө:

22.1.1. ан амьтныг нутагшуулан үржүүлэх зориулалтаар барих;

22.1.2. халдварт өвчний голомтыг устгах зорилгоор эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр ан амьтныг мэргэжлийн байгууллагаас зохион байгуулалттай агнаж устгах;

22.1.3. мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чоно агнах;

22.1.4. сорьц, дээж авах, хэмжилт хийх, им тэмдэг тавих, бөгжлөх, судалгааны хэрэгсэл зүүх зорилгоор ан амьтныг эрдэм шинжилгээний зориулалтаар түр барих.

22.2. Тодорхой нутаг дэвсгэрт ан амьтны тоог сийрэгжүүлэх, хүйсийн харьцааг зохицуулах, заазлах зорилгоор болон соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнахад төлбөрийг 80 хувь хүртэл хөнгөлж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТӨЛБӨР НОГДУУЛАХ, ТӨЛӨХ, ТАЙЛАГНАХ

23 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөх

23.1. Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна.

23.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ.

23.3. Сум, дүүргийн Засаг даргын томилсон төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан төлбөрийг бэлнээр хураан авсан тухай бүр сум, дүүргийн төсөвт тушаана.

24 дүгээр зүйл. Төлбөрийн жилийн тайлан гаргах

24.1. Төлбөрийн жилийн тайланг дор дурдсан хугацаанд гаргана:

24.1.1. ургамал, ус, ой, ан амьтны нөөц ашигласны төлбөр хураан авах эрх бүхий албан тушаалтан төлбөрийн тайлангаа дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор сум, дүүргийн татварын албанд;



24.1.2.сум, дүүргийн татварын алба тайлангаа дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн татварын албанд;

24.1.3.аймаг, нийслэлийн татварын алба тайлангаа дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад;

24.1.4.татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төлбөр, улсын нэгдсэн тайлангаа дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор.

24.2.Төлбөрийн тайлангийн маягтын загварыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА, МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

25 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

25.1.Энэ хуулийн 23.3-т заасныг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол төлбөр хураах

эрх бүхий албан тушаалтанд татварын байцаагч дараах захиргааны шийтгэл ногдуулна:

25.1.1.төлбөрийг аваагүй буюу дутуу авсан, төлбөрийн данс бүртгэл, баримтыг будлиантуулсан, хураан авсан төлбөрийг төсвийн орлогод тогтоосон журмын дагуу тушаагаагүй бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

25.2.Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувь, хэмжээг бууруулсан, төлбөрийн орлогын хэсгийг өөр зориулалтаар ашигласан албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хохирлыг нөхөн төлүүлнэ.

25.3.Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн төлбөр төлөгчид Татварын ерөнхий хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫНИХ ХУРЛЫН ДАРГА
Д.ДЭМБЭРЭЛ**



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 6 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 203 хот

ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1 "Хатан Туул" хөтөлбөрийг 1 дүгээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1 үе шатны ажлын төлөвлөгөө (2012-2016 он)-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, салбар дундын зохицуулалт хийх, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Усны үндэсний хорооны дарга Д.Цогтбаатар, Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд Ц.Дашдорж, Нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт үүрэг болгосугай.

3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган улсын төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатар, Сангийн сайд Д.Хаянхярваа, Зам,

тээвэр, барилга хот байгуулалтын сайд Ц.Дашдорж болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4 Туул голын сав газрын захиргаа байгуулж, захиргааны үйл ажиллагааны төлөвлөгөө, зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталж мөрдүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатарт даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд
С.БАТБОЛД**

**Байгаль орчин, аялалжуулчлалын сайд
Д.ЦОГТБААТАР**



*Сандуйжав овогтой
Бумаа. Луу жилтэй.
Эрүүл ахуйч, их эмч
мэргэжилтэй. Анагаах
ухааны магистр,
тэргүүлэх зэрэгтэй
эмч. Эрүүл ахуй
халдвар судлалын
хяналтын байгууллага
болон мэргэжлийн
хяналтын байгууллага,
хүнс, усны шинжилгээний
лабораториудад 36
жил тасралтгүй
ажилласан.
Эртний дэлхий дахины
түүх, түүхэн эх сурвалж
бүхий кино үзэх
сонирхолтой.*



ТА ӨВЧЛӨӨГҮЙ ХАРИН ЦАНГАСАН БАЙНА Ус-эрүүл мэнд

**Ус яагаад байгалийн энгийн, аюулгүй,
үнэгүй, үр дүнтэй хамгийн гайхамшигтай эм
болдгийг мэдэх цаг болсон.**
Ф. Батмангхелидж

Орчуулсан: Х.Шүрэнцэцэг, Химийн Ухааны доктор
Хянасан: Ж.Купул, Анагаах Ухааны доктор

**Цоргоо нээ, эрүүлийг хамгаалах салбарын
бүх цаг үеийн агуу их нээлтүүдийн
нэг үр дүнг хүртэцгээе!**

Усны тусламжтайгаар эдгээж болох өвчнүүдийн
жагсаалт:

**УС НЬ СУДАСНЫ БӨГЛӨРӨЛ, ЗҮРХ СУДАСНЫ
ӨВЧНӨӨС** сэргийлдэг.

ТӨРӨЛ БҮРИЙН ХАЛДВАРУУД - ус нь биеийн
халдварт өвчний эсрэг эсэргүүцлийг нэмэгдүүлэн,
хавдрын эс үүсэхээс сэргийлнэ;

СЭТГЭЛ ГУТРАЛ -ус нь серотонины
нейротрансмиттерийн нөөцийг жамаар нь сэргээх
замаар бие махбодод тусладаг;

НОЙР МУУДАХ - ус нь нойрны байгалийн зохицуулагч
мелатониныг боловсруулахад зайлшгүй хэрэгтэй;

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХОМСДОЛ -ус нь биеийн тамир
тэнхээг сайжруулах замаар эс бүрт цахилгаан болон
соронзон эрчим хүч үүсгэдэг;

ХОРТ ЗУРШИЛ - ус нь зарим төрлийн мансууруулах
бодис, согтууруулах ундаа болон кофейны даслаас
салахад тусалдаг;

ЯСНЫ СИЙРЭГЖИЛТ - ус нь ясны тогтолцоог
бэхжүүлдэг;

ЛЕЙКЕМ БА ЛИМФОМ – Олон төрлийн хавдраас
сэргийлэхэд тусладаг цус төлжүүлэх тогтолцооны үйл
ажиллагааг хэвийн болгодог;

АНХААРАЛ СУЛРАХ - усаар сайн хангагдсан тархи
нь өөрийн ой санамжийг шинэ мэдээллээр байнга
баяжуулахад хүрэлцээтэй эрчим хүч авдаг.

Анагаах ухаан дах шинэ эриний нээлтүүд

Таны эрүүл мэнд муудаж, яваандаа амь
насанд чинь аюул учруулах нөхцөл үүсэх үед л та үүний
шалтгаан, асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг эрж
хайж эхэлдэг. Та эмчид үзүүлж, өвчнийхөө оношийг
сонсох нь таны сэтгэл санаанд ямархуу хүчтэй цохилт



болдгийг үнэлж, цэгнэж чаддаггүй.



Өдөр бүр хэдэн мянган хүнд тохиолддог ийм золгүй байдал таны ойр дотныхоны хэн нэгэн болон танаас холуур өнгөрнө гэдэгт итгэцгээе. Америкийн эрүүлийг хамгаалахын тогтолцооны өнөөдрийн хямралын шалтгаан нь олон тооны өвчин бие махбодыг цагаас нь эрт муутгаж, хэдэн сая хүнийг үхэлд хүргэж байгаад оршиж байгаа юм. Энэхүү хямралын өртөг 2001 онд 1.2 их наяд долларт хүрч, энэ тоо жил бүр 11%-иар өсөх төлөвтэй байна. Шинжлэх ухааны салбарт бид дэлхий дээр хамгийн өндөр хөгжилтэй оронд тооцогддог ба анагаах ухааны судалгаа шинжилгээнд жил бүр олон тэрбум доллар зарцуулдаг. Хэрэв та ойрын үед хэвлэгдсэн анагаах ухааны аль нэг лавлахыг сөхөж үзвэл хуудас дамнуулан үхлийн аюултай өвчнүүдийг тоочсон байх боловч аль нэг өвчний шалтгааныг тайлбарлах болоход "Шалтгаан нь тодорхойгүй" гэж зохиогчид нь хүлээн зөвшөөрсөн байхыг харах болно. Энэ нь ихэнх эмч нар хүний бие махбодын үндсэн өвчнүүдийн шалтгааныг мэддэггүй болохыг харуулж байгаа бөгөөд түүгээр ч барахгүй ихэнхдээ өвчтөнд ямар ч тус нэмэр болохгүй, харин ч зугуухнаар, зуурдаар үхүүлэх төрөл бүрийн эмчилгээ хийх зөвшөөрлийг нийгмээс тэдэнд олгосон байдаг. Сайн мэдээ гэвэл удахгүй тэдний энэ зөвшөөрлийг цуцална. Таны одоо танилцах зүйл бол физиологийн шинжлэх ухааны хүрээнд шинэ ирээдүй нээсэн, амьд эд, эрхтэний зүй ёсны, байгалийн үйл ажиллагааг тайлбарлах мэдлэгийн цоо шинэ салбар юм. Энэ номонд эрүүл мэндтэй холбоотой нилээд хэдэн ярвигтай асуудал, тэдгээрийн шалтгаан болон байгалийн жамаар эдгээх аргын талаар авч үзнэ. Өвчний шалтгаан болон эмчлэх арга тодорхой байхад анагаахын ойлгомжгүй нэр томъёо, илүү үг огт хэрэггүй. Энд дурдагдсан бүх зүйл эмнэлзүйн болон шинжлэх



ухааны бүх талын гүнзгий судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурласан болно. 1950-иад онд Лондонгийн гэгээн Марийгийн эмнэлгийн харьяа анагаахын сургуульд элсэн орж, суралцсан хугацааг тооцохгүйгээр миний амьдралын 22 гаруй жил энэ номонд орсон мэдээллийг нийтлэх, судалж шинжлэхэд зориулагдсан. Энэ сэдэв бол олон хүнд өвчнүүдийн гол шалтгаан болох архаг усгүйжилт, түүний хүндрэл болон физиологийн хор уршгийн тухай юм. Энэ нь орчин үеийн анагаах ухаан дах жинхэнэ эргэлт гэж зарим хүн үзэж байна.

Хүний эрүүл мэндтэй холбоотой өнөөдрийн зарим асуудлуудын тухай энэхүү шинэлэг ойлголт нь дэлхийн анагаах ухаан цаашид шинжлэх ухаан, логик дээр үндэслэн, шинэчлэгдэн өөрчлөгдөх зөвхөн эхний алхам билээ.

Энэ номоо бичиж байх үедээ би, юуны өмнө өдөр тутам эм тариа хэрэглэдэг хүмүүс, ялангуяа багтраатай 15 сая хүүхдийн талаар, тэдний эцэг эхэд энэ өвчний учир шалтгааныг хурдан ойлгуулах, үр хүүхдийнхээ амьдралыг аврах энгийн, зардал мөнгө шаардагдахгүй аргыг зааж өгөхийг бодож байсан юм.



Нэгдүгээр бүлэг

Орчин үеийн анагаах ухааны алдаа юу вэ?

Ам хатах нь бие махбод ус нэхэж байгаагийн цорын ганц шинж тэмдэг гэж үздэг онол нь миний үзэж байгаагаар анагаах ухааны түүхэнд агуу их эмгэнэл авчирсан. Энэ худал хуурмаг үзлийг удиртгал болгосноор орчин үеийн анагаах ухаан өршөөж болшгүй дахин гурван том алдаа гаргасан нь нийгэмд үнэтэй тусчээ. Алдаатай дөрвөн таамаглалыг авч үзэцгээе.

1. Ам хатах нь бие махбодын ус хүсэж байгаагийн цорын ганц шинж тэмдэг гэсэн харамсмаар худал таамаглал дээр орчин цагийн анагаах ухааны бүх бүтэц бүрэлдэн тогтсон. Олон сая хүмүүсийг цаг бусын үхэлд хүргэж буй эрүүл мэндийн олон чухал асуудлуудын гол учир шалтгааныг олоход дээрх таамаглал саад болж байна.

Эдгээр хүмүүсийн өвчин зовиурын гол шалтгаан нь бие махбод маш ихээр цангаж байгааг мэддэггүйд оршиж байгаа юм. Үнэндээ бол "шинжлэх ухаанд үндэслэсэн" гэгдэх орчин үеийн анагаах ухаан нь олон жилийн өмнө хийсэн энгийн алдаанууд дээр суурилсан юм. 1764 онд германы эмч Альберхт Фон Халлер ам хатах нь ус дутагдаж буйн шинж гэж анх зарлажээ. Английн эмч Уолтер Брэдфорд Кэннон энэ санааг дэмжсэн бөгөөд Кэннон нь нөлөө бүхий хүн байсан тул түүний энэ үзэл санаа моодонд орж, шинжлэх ухааны



ном зохиолд одоог хүртэл тэмдэглэгдэн дурдагдсаар байна. Гэхдээ бүр 1867 онд Францын эмч Мориц Шифф цангах нь зөвхөн "ерөнхий мэдрэмж, энэ нь өлсөхийг мэдрэхтэй нэгэн адил" юм гэжээ. Одоо бол бид Халлер болон Кэнноны үзэл санаа буруу гэдгийг мэддэг болсон ч тэдний үзэл бодол нь өнөөгийн анагаах ухаанд зохих байр эзэлж байгаагаас бүх эмч, оюутан, залуу үеийнхнийг төөрөгдүүлсээр байна. Хүний бие махбодод дах усны зохицуулалтын зүй тогтлыг тайлбарлах шинжлэх ухааны ойлголтод гарсан энэхүү алдаа нь анагаах ухааныг зөв замаас нь төөрөгдүүлсэн юм. Шифф хүний биеийн тогтолцоог хамаагүй илүү мэддэг байсан. Шууд хэлэхэд, ам хатах нь бидний анхаарах тэр шинж тэмдэг биш. Хүний бие махбод харин өөр логик ашигладаг байна. Бие махбодод бусад үйл ажиллагаанд шаардлагатай ус ихээр дутагдаж байсан ч түүнээс үл хамааран хүнсний бүтээгдэхүүнийгажилж, залгих, энэ үйл ажиллагаанд шаардлагатай шингэн ялгаруулахад зориулж, их хэмжээний шүлс ялгаруулдаг. Ямар ч тохиолдолд биеийн усны хэрэгцээ маш их тул зөвхөн ам хатах төдийхнөөр ус дутагдаж буй дохио өгдөггүй.



Ус дутагдсаныг мэдрүүлэх олон тооны өөр нарийн механизмууд хүний биед байдаг. Ам хатахыг мэдрэхгүйгээр хүн маш хүчтэй усгүйжсэн байх нь бий. Усгүйжих нь олон янзын хүнд хэлбэрүүдээр илэрдэг бөгөөд зарим нь амь насанд аюултай. Орчин үеийн анагаах ухаан бие махбодын дотоод хаталтын шинж тэмдгийг буруугаар тайлбарлаж, өөр ямар нэг өвчинтэй холбон үздэг байна. Ингэснээр өвчнийг усгүйжилттэй тэмцэхийн оронд тухайн өвчнийг эмчлэхийн тулд хор болох эм өгдөг. Ам хатах нь бие махбод усгүйжсэний хамгийн сүүлийн шинж тэмдгүүдийн нэг юм. Ам хатаж, ус дутагдаж буй талаар дохио өгөх энэ үед бие махбод аль хэдийн өөрийн гүйцэтгэх зарим нэг үйл ажиллагаанаасаа татгалзахад бэлтгэж эхэлсэн байдаг. Яг ийм маягаар ферментийн үүргүүд багассанаар хөгшрөлт явагддаг. Усгүйжсэн бие махбод уян хатан чанар болон бүтээх чадвараа алддаг. Тухайлбал, бие махбод усгүйжилттэй тэмцэхдээ инсулин ялгаруулдаг нойр булчирхай эд эсээ алдсанаас өсвөр насныхны

чихрийн шижин өвчин үүсдэг.

2. Анагаах ухааны хоёрдах эмгэнэлт алдаа нь усыг зөвхөн уусгагч, янз бүрийн бодисуудыг биеэр зөөдөг субстанци гэж ойлгодог явдал юм. Ус нь идэвхгүй субстанци биш ба бие махбодод хоёр чухал үүрэг гүйцэтгэдэг. Нэгдүгээрт амьдралын хэвийн үйл ажиллагааг хангадаг. Хоёрдугаар бүр чухал үүрэг бол ус нь амьдралын үндэс суурь болдог оршино. Орчин үеийн анагаах ухаан зөвхөн эхнийхийг л хүлээн зөвшөөрдөг учраас усгүйжилт нь амьдралд аюултай үйл явц гэж тооцогддоггүй. Энэ үйл явцын чухлыг ойлгож ухаарснаар бид өөрийн эрүүл мэндээ хамгаална.

3. Анагаах ухаан дах гуравдугаар алдаа нь - орсон усыг бие махбод насан туршид тогтмол идэвхтэй зохицуулж байдаг гэсэн таамаглал. Нас ахих тутам хүн цангах мэдрэмжийг бодитойгоор үнэлэхээ больж, нэн чухал эрхтэнүүдийн эд эс шүүслэг чавганаас хатаасан хар чавгад хувирах хүртэл усыг улам бүр бага хэмжээгээр уудаг. Бие махбод усгүйжих энэ явцыг эцсийн үе шатанд хүргэхгүйн тулд эхний хам шинжүүдийг таньж мэдэх нь маш чухал байдаг.

4. Өнөөдрийн анагаах ухааны дөрөвдүгээр алдаа нь - Хүний биеийн усны хэрэгцээг дурын ямар нэгэн шингэний тусламжтайгаар хангаж болно гэж баталж байгаа онол юм. Энэ нь одоогийн анагаахын том алдаа юм. Үйлдвэрийн аргаар гаргасан нийтэд тархсан зарим ундаанууд хүний бие махбодод энгийн усыг бодвол өөрөөр үйлчилдэг. Зарим төрлийн ургамлууд кофеин, кокаин боловсруулдаг шалтгааныг мэдсэнээр та үүний учрыг ойлгох болно.

Энэ номонд эрүүл мэндийн талаар дэлхийн шинжлэх ухаанд хийсэн нэг агуу их нээлтийн тухай болон ам хатах нь бие махбод усгүйжсэний цорын ганц шинж тэмдэг хэмээн баталсан алдаатай онол анагаах ухааны түүхэн дэх нэгэн эмгэнэл болсон талаар өгүүлэх болно. Товчхон хэлэхэд, шинжлэх ухааны энэхүү шинэ ойлголтоор хүний бие махбод нь зориудын бус архаг усгүйжилтийг олон аргаар, тодруулбал, анагаах ухаанд одоогоор мэдэгдэж буй өвчнүүдтэй тэнцүү тооны аргаар өөрийгөө мэдээлж байдаг.

Эцсийн дүнд энэ талын мэдлэг дутмаг, итгэмтгий Америкчууд өөрийн эрүүл мэнд, цалин хөлсөөрөө эрүүлийг хамгаалахын өсөн нэмэгдэж буй зардлыг бүрдүүлэхэд хүрч байна. Байнгын усгүйжилт нь биеийн химийн найрлагыг тогтмол өөрчилж байдаг гэдгийг бид ойлгох ёстой. Усгүйжилтээр үүссэн химийн шинэ найрлага нь тогтворжиж, улмаар бүтцийн, тэр тусмаа генийн өөрчлөлтүүдийг бий болгодог. Иймээс усгүйжилтээс сэргийлэх нь нэн чухал ач холбогдолтой. Ийм учраас л хүүхдийн чихний халдварт бус өвчин, багтраа миний хувьд анхаарлаа хандуулах гол асуудал болсон юм. Хүүхдэд багтраа үүсгэх хэмжээний усгүйжилт нь эцэстээ генийн өөрчлөлт, аутоиммуны өвчин, тэр ч байтугай насанд хүрэх үед нь хорт хавдарт ч хүргэж болох аюултай юм.

Бие махбодын өөрийгөө эмчлэх чадварыг нэмэгдүүлэх нь эрүүл мэндийн асуудлуудыг эмийн хүчээр дарах хандлагыг бүрэн халах болно. Өндөр үнэтэй эмчилгээ бус харин өвчнөөс урьдчилан сэргийлэх нь анагаах ухааны гол хандлага болж байна.



Булган уул



Булган уул нь Архангай аймгийн Цэцэрлэг суманд оршдог бөгөөд байгалийн үзэсгэлэнт байдал, түүхийн дурсгалт зүйлсийг нь хамгаалах зорилгоор 1965 онд улсын тусгай хамгаалалтанд авсан. 1995 онд УИХ-ын 26 дугаар тогтоолоор байгалийн дурсгалт газрын ангилалд шилжүүлсэн. Булган уул нь урсгалт газрын дундуур зүүн хойш чиглэн тогтох бөгөөд хоёр Тамирын голын усны хагалбар болдог. Энэ бүсэд Аригийн нуруу, Хамрын нуруу, Хялалзахын нуруу, Мурилзахын нуруу зэрэг боржин хаднаас тогтсон олон нуруунууд байхаас гадна, зүүн өмнө талд орших Таван цохионоос эгц хойш Цагдуулт хэмээх боржин хадат уул, Малгай зэрэг өндөр уулууд оршдог. Булган уулын зүүн хормойд Жамганы рашаан, баруун хэсэгт Ганц модны рашаан гэх мэт рашаан ус бий.

Булган уул нь ой мод, хадлан бэлчээрийн ургамлаар нэн баялаг бөгөөд тус орны ой хөвч, ойт хээрийн бүсэд тохиолддог ургамлын ихэнх зүйл ургадаг. Гүзээлзгэнэ, хад, тошлой, самар, таван салаа, тарваган шийр, сөд, царван, алтан гагнуур, бамбай, ганга, нохойн хошуу, гишүүнэ, хунчир зэрэг эмийн ургамалтай. Мөн цагаан төмс, мэхээр, бүүргэнэ, гоньд зэрэг хүнсний ургамалтай. Булган ууланд хангайн бүсэд ургах хар мод, хуш зэрэг шилмүүст мод, хус, улиас, улиангар, хайлаас зэрэг навчит модод ургана.

Булган уул нь хүн ам олонтой, хөл хөдөлгөөн ихтэй Цэцэрлэг хотод ойрхон байдаг учир ан амьтад нь дүрвэн зайлсан байдаг. Буга, бор гөрөөс, хүдэр, шилүүс, гахай, мануул, хэрэм, жирх, үен солонго, чоно, туулай зэрэг амьтад мэр сэр үзэгдэнэ. Ятуу хөтүү, бүргэд, ууль, шар шувуу, харцага зэрэг жигүүртэн шувууд бий.

Сүйхэнт уул



Сүйхэнт нь Дорноговь аймгийн Мандах сумын нутагт оршдог бөгөөд Монгол оронд төдийлөн элбэг тохиолддоггүй чулуужсан мод байдаг байгалийн үзэсгэлэнт газар юм. Чулуужсан модны үлдэгдлүүд нь бага хэмжээтэй боловч сүүлийн жилүүдэд аймаг сумын төв рүү зөөх явдал ихэсч нөөц нь багасч байгаа учраас 1996 онд УИХ-ын 43 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтанд авчээ. Чулуужсан модны зарим нь 4м бөгөөд хожуул нь 76-189 см диаметртэй.

Эдгээр мод нь эрт дээр үед энэ нутагт ой байсныг гэрчилнэ. Одоогоос 140-150 сая жилийн өмнө ургаж байсан араукария хэмээх эртний шилмүүст шув шулуухан өндөр мод энд ургаж байжээ. Монголын говьд байсан энэ өндөр модыг оросууд "болотны капирас" буку "намгийн агар-майлс" гэдэг. Дэлхий дээр энэ мод 20-иод төрөл байдгийн зарим нь Өмнөд Америк, Австрали, Баруун өмнөд Азид одоо ч байдаг ажээ. Сүйхэнтийн чулуужсан мод нь 0.5 ам км-ээс ихгүй багахан талбай эзэлнэ. 1946 онд Оросын эрдэмтэн И.А.Ефремов Сайншанд хотын ойролцоох Чойлингийн



ууланд 6 хэсэг болж хугарсан нийт 11 метр урттай, нэг метр бүдүүн мод үзэж харсанаа тэмдэглэжээ.

Мөн чулуужсан модны 4м бүдүүн хожуултой тааралдаж байжээ. Дэлхийн зарим оронд байдаг чулуужсан ойгоос Сүйхэнт ялгардаг бөгөөд чулуужсан мод нь үндэс, мөчир, холгостойгоо, өсөлтийн цагираг нь хүртэл тов тод үлдсэн байна. Цайвар цагаан, улаан ногоон өнгөтэйгөөс гадна магма, галт уулын чулуулаг, боржингийн хольцтойгоороо онцлог юм. 1970 оны сүүлчээр Сүйхэнт уулын чулуужсан моднуудын унанги, хожуул зэрэг нь огт хөндөгдөөгүй хадгалагдсан байсан

боловч харамсалтай нь зах зээл рүү шилжсэн үед эдгээр үнэт чулуужсан модыг хулгайлан сүйтгэж урд хөрш рүү зөөсөн байна.

Сүйхэнт орчим нь говийн бүсийн хайрган хөрстэй учраас ургамалжилт нь зүйлийн бүрдэл нөөцөөр элбэг бус юм. Олон наст бударгана, баглуурт ургамал ургана.

Сүйхэнтийн бүсэд хулан, хар сүүлт, цагаан зээр, аргаль зэрэг туурайтан байхаас гадна элсний зусаг, говийн алагдаага, сибирийн алагдаага зэрэг олон зүйлийн мэрэгч амьтад амьдардаг.

Ээж хайрхан



Ээж хайрхан уул нь Алтайн өвөр говийн уудам зайд уулс хоорондын цөлөрхөг хотгорт орших жижиг ширхэгт боржин чулуунаас тогтсон хад чулуурхаг өнчин уул юм. Монголын баруун өмнө зүгт Алтай хотоос 200 км зайтай оршино. Д.т.д 2277 м өндөр бөгөөд 1992 оноос тусгай хамгаалалтанд авчээ.

Ээж хайрхан ууланд өвөрмөц тогтоц, ховор сонин үзмэрүүд олон байдаг ба зүүн өмнө хажуугийн чулуулгийн гав судал дагаж цувран тогтсон ногоон хүрээтэй 9 чулуун тогоо бий. Тогоонуудын амсарын дундаж өргөн нь 2-3м бөгөөд хоорондоо 40-50см өндөр чулуун босгоор нэг нь нөгөөтэйгөө холбогдоно. Эдгээрийн 4 дэх нь хамгийн том бөгөөд түүний гүн нь 4 м хүрдэг. Харин 9 дэх тогоо нь бусдаасаа нилээд тусгаарлагдмал. Энэ ууланд хүн амьдарч байсан ул мөр бүхий агуй бий. 9 тогооны ойролцоо орших ба тэдгээр тогоо харсан нүүрэн талыг битүүлж хаалга, гэгээвч гарга тохижуулсан ламын агуй юм. Түүхийн ухааны доктор Д.Очирбат судалгаа хийсний үр дүнд Ховог сайрын

торгууд гаралтай Равдан гэгч лам 1923 оноос нилээд хэдэн жил амьдарч байсныг тогтоожээ.

Ээж хайрхан уул нь уулс хоорондын цөлөрхөг хотгорт орших боржин чулуун уул бөгөөд 93 зүйл ургамал тархсан. Ийм олон зүйлийн ургамал ургадаг нь экологийн өвөрмөц бичил орчнууд байдгийг харуулж байна.

Ээж хайрхан уул нь Монгол Алтайн нуруу, Говь Алтайн нурууны хоорондын хотгорт орших бөгөөд аргаль, янгир, ирвэс зэрэг нэн ховор, ховор том хөхтөн амьтадын хоёр тийш нүүдэллэх коридор болж өгдөгөөрөө чухал ач холбогдолтой. Энд аргаль, янгир, цоохор ирвэс, хярс, мануул, үнэг, чоно элбэг байдаг. Хахилаг ятуу, хулан жороо, ногтруу, уулын цэгцгий, жороо тоодог зэрэг олон зүйл ховор шувууд бий. Ээж хайрхан уулыг тойроод буудайн тариалангийн талбай бий. Нутгийн хүмүүс тариалангийн талбайд зориулж 33 метр өндөр, 12 метр өргөн даланг барьжээ.

ШИНЭ НОМ 2012 ОН



1. "Бохир ус зайлуулах систем" Улаанбаатар хот 2012 он

Орчин үед үйлдвэрийн болон ахуйн бохир ус зайлуулах системийн асуудал бол байгаль орчноо хамгаалах нэн тэргүүний зорилтын нэг юм. Энэ асуудлыг ОХУ-н эрдэмтдийн бүтээлүүдээс бүрдсэн томоохон хэмжээний номыг орчуулан мэргэжлийн инженер техникийн алба, суралцагч оюутнууд, судлаачдад зориулан гаргасан байна. Энэ номонд ус зайлуулах систем, ус зайлуулах сүлжээ, бохир ус шахах тухай, бохир ус цэвэрлэх үүрэгтэй байгууламжууд, бохир усны тунадас боловсруулах, халдваргүйжүүлэх, бохир ус цэвэрлэх, тунадас боловсруулах байгууламжийн ерөнхий иж бүрдлийн шийдлүүд, цөөн хүн амтай суурин газар, тусда орших объектын ус зайлуулах систем, байгаль цаг уурын онцгой нөхцөл дэх ус зайлуулах систем зэрэг асуудлын талаар дэлгэрэнгүй тусгажээ.

Уг номыг Техникийн ухааны магистр, МУ-ын зөвлөх инженер, МУ-ын "Үйлчилгээний гавьяат ажилтан" О.Эрдэнэбаатар, Техникийн ухааны мастер, МУ-ын зөвлөх инженер, МУ-ын "Аж үйлдвэрийн гавьяат ажилтан" Б.Пүрэвжав нар орчуулж, Доктор Ph, дэд профессор Л.Эрдэнэтуяа, Техникийн ухааны магистр, МУ-ын зөвлөх инженер Ө.Цэдэндамба нар хянан тохиолдуулсан байна.


2. Ф.Батмангхелидж "Ус эрүүл мэнд" (Та өвдөөгүй харин цангасан байна.) Улаанбаатар 2012 он

АНУ-ын иргэн, Доктор Ф.Батмангхелидж бичсэн энэ ном эрүүл мэндийг юунаас ч эрхэмд тооцдог хэн хүний унших тавилантай хамгийн чухал ном ч байж магад.

Ус яагаад байгаль дахь хамгийн гайхалтай энгийн аюулгүй, үнэгүй, үр дүнтэй эм болохыг бид мэдэх цаг нь болсон.

Хүний бие махбодид усны гүйцэтгэх үүргийн талаарх 20 жилийн эмнэлзүйн болон эрдэм шинжилгээний ажлын үр дүн нь ус, тийм ээ энгийн ус? Эрүүл мэндтэй холбоотой ямар ч асуудлыг даван туулахад танд тусална гэдгийг энд баталж байна.

Та энэ номноос цангалт болон архаг усгүйжилтын талаар бие махбодиос танд өгч байгаа янз бүрийн дохионуудыг мөн эрүүл байхын тулд өдөрт хичнээн хэмжээний ус ба дарс хэрэглэхийг тодорхойлж сурах болно. Мөн яагаад цай, кофе, ундаа зэрэг бусад шингэн зүйл усыг орлож чаддаггүй, яагаад ус нь хоолны дэглэм барилгүйгээр тураах гол хүчин зүйл болдгийг мэдэх болно. Түүгээр ч барахгүй хүний арьсыг эрт хөгшрөхөөс сэргийлэхийг, яаж цусны даралт ихсэх, багтраа, харшил өвчнөөс ангижрахыг, яаж зүрхний дутагдал, цус харвалт, хавдар зэрэг аюулт өвчин эмгэгээс сэргийлэхийг энэ номноос мэдэх боломжтой юм.



3. Ф.Батмангхелидж "Ус анагааж, эм хөнөөдөг" (Энгийн аргаар эрүүлжих гарын авлага) Улаанбаатар хот 2012 он

Энэ шинэ номын зорилго нь орчин үеийн анагаах ухааны уламжлалт ойлголтыг өөрчлөхөд оршиж байгаа юм.

Уг номонд дурдсан бодит үр дүн бүхий нээлтүүд нь бүх улс орны анагаах ухааны практик үйл ажиллагааг өөрчлөн, зарлага нь хэтэрсэн хэрэггүй эмийн сурталчилгаа, ашиг хонжоо хайсан байдалд суурилсан өнөөгийн систем нь эрүүл байх жам ёсны, физиологийн үндэслэл бүхий хандлагад зайлшгүй зай тавьж өгнө гэдэгтэй та танилцах болно.



4. Ф.Батмангхелидж "Ус таргалалт, хорт хавдар, сэтгэл гутралаас сэргийлэх байгалийн гаралтай эм" (Усны тусламжтайгаар эрүүл мэндээ сайжруулцгаая) Улаанбаатар хот 2012 он


Энэ номыг уншиж дуусахад таргалалт, хорт хавдар, сэтгэл гутрал нь хүний бие организм усгүйжилттэй хамааралтай болох тухай та ямар нэгэн эргэлзээгүй болно.

- Ус яагаад хорт хавдар, таргалалт, сэтгэл гутралаас сэргийлэхэд тусалдаг вэ?
- Ус яагаад хүний илүүдэл 14-20кг жингээс ангижрахад тус болдог вэ?
- Ус яагаад дархлааг сайжруулдаг вэ?
- Яагаад тархинд усны "Цэвэр эрчим хүчийг" ашиглах нь хүний бусад бүтээгдэхүүний "Бохир эрчим хүчийг" ашигласнаас илүү тохиромжтой байдаг вэ? Зэрэг олон сонирхолтой хэрэгтэй асуултын хариуг энэ номноос авах бүрэн боломжтой.

Номын цагаан буян дэлгэртүгэй. Та энэ номыг авахыг хүсвэл МНААҮХолбоонд хандаарай. 70101779

ТАНЫ НОМЫН САНД

"Ус хангамж ба ариутгах татуурга" мэргэжлээр тусгай дунд боловсролын сургуулиудад суралцаж байгаа оюутнуудад сургалтын материал болгох зорилгоор дараах номнуудыг орос хэлнээс орчуулан гаргасныг танилцуулж байна.



1.Л.С.Алексеев "Усны чанарын хяналт" Улаанбаатар хот 2009 он

Уг номонд

- Байгалийн болон техникийн усыг боловсруулах процессын технологийн хяналт
- Бохир ус цэвэрлэх ажиллагаанд тавих технологийн хяналт гэсэн үндсэн 2 бүлэгт усны чанарын хяналтын асуудлыг авч үзсэн байна.


2.Ю.В.Воронов, Е.В.Алексеев бусад "Бохир ус зайлуулах систем" Улаанбаатар хот 2009 он

Уг номонд

- Ариутгах татуургын систем ба түүний схем
- Шугам сүлжээний гидравли тооцоо
- Бохир усны найрлага болон шинж чанар
- Биологийн цэвэрлэгээний байгууламж
- Бохир усыг физик, химийн аргаар цэвэрлэх
- Үйлдвэрийн бохир усны цэвэрлэгээ
- Усан сангуудыг бохирдлоос хамгаалах, цэвэршүүлсэн бохир усыг зохистой ашиглах зэргийг дэлгэрэнгүй тусгажээ.

3.М.А.Сомов, Л.А.Квитка "Ус хангамж" Улаанбаатар хот 2009 он

- Уг номонд:
- Ус хангамжийн эх үүсвэр
- Ус түгээх сүлжээ
- Ус цэвэрлэх байгууламж
- Ус дамжуулах хоолой, тэдгээрийн тоноглол
- Усны бэлтгэл ажиллагаа зэрэг асуудлыг хөндөж тавьсан.





4.Г.Н.Жмаков "Ус хангамж болон ус зайлуулах системийн тоног төхөөрөмжүүдийн ашиглалт" Улаанбаатар хот 2009 он

Уг номонд:

- Ус хангамж болон ус зайлуулах системийн ашиглалтын ерөнхий байдал
- Ус дамжуулах болон бохир ус зайлуулах насосны станц, сэнс, насосны төхөөрөмжүүдийн ашиглалт
- Ус зайлуулах сүлжээний ашиглалт
- Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын ашиглалт зэрэг асуудлууд оржээ.



5.В.А.Орлов, Е.В.Орлов "Шуудуугүй технологийн аргаар ус хангамж, ариутгах татуургын системийг барих, сэргээн засварлах."

Уг номонд:

- Дамжуулах хоолой тавих технологи
- Бичил хонгил байгуулах аргаар дамжуулах хоолой тавих технологи
- Полиэтилен тахир хоолойг татах технологи
- Зэвэрдэггүй гангаар шугамын эвдрэлийг сэргээн засварлах арга, обьктоо сонгох зэрэг асуудлыг дэлгэрүүлэн орчуулсан байна.

ЭРҮҮЛ МЭНДГИЙН ШУХААЙ МЭРГЭЭДИЙН СУРГААЛИАС

- Эрүүл мэнд гэдэг бүх юм биш, гэхдээ эрүүл мэндгүй бол бүх юм юу ч биш.
- Баяр хөөртэй зүрх хамгийн сайн эмч, харин шархадсан зүрх ясыг ч яйруулдаг.
- Биеийн бүх хөдөлгөөний дотроос хамгийн бузгай нь инээд бөгөөд тэр нь хоол боловсруулж, цусны эргэлтийг тэтгэж, бүх эрхэтний амьдралын хүч чадлыг сэргээдэг.
- Аль ч эмийг хөдөлгөөн орлож чаддаг байхад энэ дэлхийн ямар ч эм хөдөлгөөнийг орлож үл чадна.
- Шингэхгүй хоол бол идсэн эзнээ хамт иддэг. Тийм учир хэмжээтэй зоогло.
- Аз жаргалын төлөө хундага өргөхдөө бид эрүүл мэндээ муутгадаг.
- Эрүүл мэнд үгүй бол эд баялаг, нэр төр гэдэг дэмий зүйл.
- Үргэлжийн баяр баясгалантай байвал хүн эрүүл чийрэг байна.
- Эрүүл гуйлгачин өвчтэй ноёноос илүү жаргалтай байдаг учраас л эрүүл мэнд бүх баялагаас хамгийн жинтэй нь болдог.
- Бидний аз жаргалын аравны есөн хувь нь эрүүл мэндээс хамаардаг.
- Үд дунд багахан, орой түүнээс ч бага ид, бидний эрүүл мэндийг ходоод маань дархалж байдаг юм.
- Хөгжилтэй, цовоо сэргэлэн хүний өвчин ч түргэн илааширдаг.
- Эдгэрэх итгэл төгс байвал өвчний тэн хагас нь эдгэрлээ гэсэн үг.
- Аз жаргал юуны түрүүнд эрүүл биед оршино.
- Сайн эрүүл мэнд гэдэг сайн дадал зуршлын үр дүн юм.

**Сократ
Соломон**

Х.Гуфеланд

**Тассо
Абуль Фараж
К.Жером
Эд Уйнний
Д.Леббок**

**А.Шоленгауэр
А.Шоленгауэр**

**М.Сервантес
К.Бестрем
Ф.Вольтер**


**А.Линкольн
Оскар Уайльд**

САЛБАРЫН АЖИЛ ХЭРЭГЧ ЭМЭГТЭЙ



Доржжигжид овогтой Мягмарсүрэн

1978.6.20 нд Улаанбаатар хотод төрсөн.
1986-1996 онд 10 жилийн 53-р сургууль төгссөн
1996-2001 онд МУШУТИС-ийн "Хими Технологийн Сургууль"-ийг
Инженер физикч мэргэжлээр төгссөн
2001-2006 онд хувиараа ажилласан
2006 оноос ОСА-ын "МОНТС" ХХК-ийн захирлаар ажиллаж байна.



“Насос констракшн” ХХК
Худалдаа үйлчилгээ



“ИРКУТСКПРОМОБОРУДОВАНИЕ” ООО
Албан ёсны гэрээт борлуулагч

К, ЭЦВ болон бүх төрлийн насос, хөдөлгүүр, сэнс бэлнээр болон захиалгаар нийлүүлнэ. Холбооны гишүүн байгууллагуудад 5% хямдралтай.

СХД 14-р хороо 1-р хороолол Цамбагарав үйлчилгээний төвийн ард
Утас: 96652387, 96687342, 99175185, 688185 Факс: (976-11) 688185
N-мэйл хаяг: nasos_mgl@yahoo.com